МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,149.229... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.06.22. Пүрэв. №121 (4735) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

ТУУЛ ГОЛЫН БУРГАСЫГ СҮЙТГЭСЭН КОМПАНИЙН ЛИЦЕНЗИЙГ ЦУЦАЛЛАА

II нүүрт

УЛС ТӨР

С.ОДОНТУЯА: АРДЧИЛЛЫНХАН ХИЙНЭ Л ГЭЖ АМЛАСАН БОЛ ХИЙДЭГ

VI нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

## Архины шил түймэр болдгийг мэдэх үү

Г.ГАНЧИМЭГ

Онцгой байдлын газрын алба хаагчид Төв аймгийн Мөнгөнморьт, Эрдэнэ сум, Булган аймгийн Тэшиг, Дорнод аймгийн Баянтүмэн, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд гарсан түймрүүдийг бүрэн унтрааж, орон нутгийн удирдлагуудад хүлээлгэж өгсөн байна. Одоогоор улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар нэг түймэр асч, гурван түймэр цурманд орсон байдалтай байгаа аж. Тодруулбал, Булган аймгийн Тэшиг сумаас 70 км-т Хужирт багийн Эг Тарвагатайн бэлчирт гарсан ойн түймрийг унтраахаар Булган, Орхон аймгийн Онцгой байдлын газраас 50, Зэвсэгт хүчний 186 дугаар ангиас 63 алба хаагч, орон нутгаас 29 иргэн, нийт 142 хүн 11 автомашин, 21 морьтойгоор ажиллаж байгаа талаар Онцгой байдлын ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд дурдагджээ. Эдгээр түймрийн хэд нь хүний санамсар болгоомжгүй үйлдлээс болж гарсан бол.

Үргэлжлэл нь III нүүрт

# ГУРАВХАН САЯ ХҮНИЙГ БҮРТГЭЖ ЧАДДАГГҮЙ ЮМ УУ, ХҮСЭХГҮЙ БАЙНА УУ

Б.ТОГТОХ

Ахынх маань уг нь Баянгол дүүргийн ...дугаар хороонд эхнэр, хоёр хүүхдийн хамт амьдардаг. Хоёр хүүхэд нь насанд хүрээгүй, сургууль цэцэрлэгийн насных. Гэтэл Ерөнхийлөгчийн сонгуулиа өгнө үү гэсэн урилгыг хорооноос өгөхдөө нийт таван ширхэгийг өгчээ. Насанд хүрсэн хоёрхон хүн байдгийг хэлж гурван урилгыг буцаах гэхэд нь хорооны ажилтан "Танай байранд, таны амьдардаг тоотод бүртгэлтэй хүмүүс. Бид мэдэхгүй" хэмээгээд гарч оджээ. Ах маань хаяганд нь бичигдсэн гурван нөхрийг нэрийг ч нь мэдэхгүй огт танихгүй хүмүүс байсан аж. Ерөнхийлөгчийн сонгууль болж буй энэ өдрүүдэд манай ахынх шиг асуудал нэг биш нэлээд олон айлд тохиолдож байгаа нь ажиглагдах болов. Бүр эхнэр нөхөр хоёр өөрсдөө байхгүй атлаа өөрийнх нь гэрийн хаяг дээр долоон хүн бүртгэлтэй байсан тухай нэгэн иргэн өөрийн цахим хуудсандаа бичсэн байх юм. Мөн өчигдөрхөн нэр дэвшигч Х.Баттулга иргэдтэйгээ уулзах үеэр Болор цомын эзэн, яруу найрагч Ц.Хулан өөрийнх нь гэрийн хаяг дээр хоёр ч хүн нэмэгдчихсэн гэдгийг баримтаар харуулав. Гэтэл өөрийнх нь хань, гадаадад сурдаг хүү хоёрынх нь нэр ор сураггүй алга болжээ. Иргэний бүртгэлийн иймэрхүү дампуу асуудал жил жилийн сонгуулийн үеэр сөхөгддөг ч асуудал тэгсхийгээд намждаг. Өнгөрсөн 2016 оны УИХ-ын сонгуулиар ч гэсэн иймэрхүү асуудал бүр эрчээ авсан гэхэд болно. Төрийн түшээгийн суудалд ямар ч хамаагүй аргаар тухлах гэсэн улстөрчид аймаг аймаг алгасан автобусаар иргэдийг нүүлгэн шилжүүлж байлаа. Хөвсгөл, Баянхонгор, Увс аймаг руу түр шилжин иргэдийн тоо 5000-аар тоологдож байсан нь худлаа биш. Нөгөөхийг нь манайхан "царцаа" хэмээн нэрлэчихсэн. Хаана ч хамаагүй үсэрч дэвхэрч явдаг богинохон настай энэ амьтантай зүйрлэсэн нь тун ч оносон мэт.

Үргэлжлэл нь III нүүрт

ХЭН НЬ ХЭН БЭ


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# "МОН-УРАН"-Ы Б.НАРАНХҮҮ

Х.НОРЖИН

*"Хэн нь хэн бэ" булан маань Монгол төрийн түшээдийн хэн нь хэн бэ, өмнө нь хэн байв, одоо хэн болсон, юу хийж байна, сонгогчдынхоо итгэл найдварыг дааж чадах түшээ мөн үү гэдгийг тольдон уншигчиддаа хүргэж байгаа билээ. Өмнөх дугаартаа УИХ-ын 1-15 тойргийн гишүүдийг онцолж, нэр дэвшигчдийн намтар цаашлаад төр түших ажлаа хэр хийж буй талаар нь өгүүлсэн. Тэгвэл энэ удаагийн дугаарт, УИХ-ын 16 дугээр тойрог болох Дундговь аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Б.Наранхүүг онцолж байна. Ирэх долоо хоногийн дугаартаа Дорнод аймгийн түшээг онцлох болно.*

Дэлгэрэнгүйг V нүүрнээс

ОНЦЛОХ МЭДЭЭ

## Тариаланч, ногоочдод "Итгэлийн зээл" олгоно гэв

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Сэлэнгэ аймагт ажиллаж байна. Өчигдөр тэрбээр Мандал сумын иргэдтэй уулзалт хийсэн бөгөөд дараа нь Баянгол сумын иргэдтэй уулзаж, тэдний асуултад хариуллаа. Ерөнхий сайд "Манай Засгийн газар ажил аваад 10 сар орчим болохдоо макро эдийн засгийг тогтворжуулж, эдийн засагт эерэг үр дүн авчирлаа.

Эдийн засагт нэгэнт ногоон гэрэл аслаа. Иймд ирэх оноос цалин, тэтгэвэр нэмэх шийдвэр гаргасан" гэв. Тэтгэврийг ирэх оны нэгдүгээр сарын 1-нээс, цалинг 2019 оноос нэмэхээр шийдвэрлэжээ. Зөвхөн тэтгэврийн нэмэгдэлд гэхэд 150 тэрбум төгрөг зарцуулахаар ирэх оны төсөвт тусгасан аж. "Манай улс ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдсан нь зөв, Оюутолгой, Тавантолгой зэрэг ордоо хөдөлгөж, иргэддээ үр дүнг нь хүртээх цаг болсон" гэдгийг орон нутгийн иргэд Ерөнхий сайдад хэлж Ноён уулаа хөндөхгүй байхыг захиж байлаа.

чухал ХҮН

## Л.Дүгэржав: АНТАРКТИДАД "УЯХАН ЗАМБАТИВИЙН НАРАН"-ГАА ХАДААЖ МӨС ХАЙЛАХЫГ ХАРАХ НЬ МИНИЙ МӨРӨӨДӨЛ

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
Г.ГАНЧИМЭГ

*Энэ удаагийн "Чухал хүн"-д уригдсан эрхэм бол Антарктид судлалын төвийн захирал, профессор, Sc.D Лхамсүрэнгийн Дүгэржав. Түүний унасан газар Азийн цээжин дэх хөх Монгол, харин хоёр дахь эх орон нь Болгар, гурав дахь "нутаг" нь зургаа дахь тив юм. Антарктидын "суугуул" тэрбээр төрөлх эх орондоо ирээд удаагүй байна. Холын зам, урт аяны хүнээс үг сонсохын тулд Монгол Улсын ШУТИС-ийг зорилоо. Түүний удирдаж, үйл ажиллагааг нь зангиддаг Антарктид судлалын төв энд байрладаг учраас тэр. "Хувьтай хүн хур бороон"-оор гэгчээр энэ зуны ган гачгийг тайлсан их уснаар бид уулзав.*

**-Та бол олон хүний хувьд цоо шинэ ертөнц. Тиймээс ихэнх нь таныг Увс аймгийн Хяргас нуурын хөвөө хавьцаа төрсөн байх гэж таамаглаж байгаа болов уу. Ер нь та хаана мэндэлж, өссөн бол?**

Үргэлжлэл нь VI-VII нүүрт




ХААН банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2355.00 | 2369.00 | ФУНТ | 2948.00 | 3052.00 |
| ЕВРО | 2594.00 | 2655.00 | РУБЛЬ | 39.30 | 41.40 |
| ИЕН | 20.92 | 21.31 | ЮАНЬ | 342.00 | 347.60 |

Худалдаа хөгжлийн банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2350.00 | 2367.00 | ФУНТ | 2960.00 | 3040.00 |
| ЕВРО | 2592.00 | 2663.00 | РУБЛЬ | 39.23 | 42.18 |
| ИЕН | 20.81 | 21.40 | ЮАНЬ | 343.00 | 347.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Д:Бат-Эрдэнэ: 50 сая вонн авсан нь тогтоогдвол нэр дэвшигчийн жагсаалтаас хасах хуультай

Н.БАТЗАЯА

СЕХ-оос Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой цаг үеийн асуудлаар өчигдөр мэдээлэл хийлээ. Мэдээллийн эхэнд МАХН-наас нэр дэвшигч С.Ганбаатарт Солонгос улсын иргэн мөнгө өгсөн гэх асуудлыг шалгуулахаар болсон талаар мэдэгдсэн юм. Тодруулбал, АН-аас нэр дэвшигч Х.Баттулгын Баянзүрх дүүргийн иргэд, сонгогчидтой хийсэн уулзалтын үеэр УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатарыг Солонгос улсын иргэнээс 50 сая вонн авсан гэж ярьсан билээ. Үүнтэй холбогдуулан уг асуудлыг шалгуулах нь зүйтэй хэмээн үзэж, Баянзүрх дүүргийн иргэн н.Баасанжаргал Сонгуулийн ерөнхий хороонд гомдол гаргасан байна. Мөн нэр дэвшигч С.Ганбаатарт 50 сая вонн өгсөн БНСУ-ын иргэн Юу Ван Сү хэргээ хүлээн зөвшөөрч, нотлох баримтыг илгээжээ. Мөн тэрбээр уучлалт хүсч, шалгаж өгнө үү хэмээн Сонгуулийн ерөнхий хороонд хандсан гэнэ. Энэ тухай СЕХ-ны Хууль эрхзүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ "Хэрэв шүүх, цагдаагийн байгууллагын шалгалтаар нэр дэвшигч С.Ганбаатар мөнгө авсан нь эцэслэн тогтоогдвол Сонгуулийн тухай хуульд заасанчилан нэр дэвшигчийн нэрсээс хасна" гэв.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Туул голын бургасыг сүйтгэсэн компанийн ЛИЦЕНЗИЙГ ЦУЦАЛЛАА

Б.ЭРХЭС

Богдхан уулын дархан цаазат газрын Ихтэнгэрийн амны хязгаарлалтын бүсэд Туул голын бургасыг сүйтгэж, барилга барьж байгаа тухай мэдээлэл олон нийтийн анхаарлын төвд орсон. Тэгвэл үүнтэй холбогдуулан БОАЖЯ-наас уг асуудлаар мэдээлэл хийлээ. Тодруулбал, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ч.Гал мэдээлэл өгсөн юм. Түүний хэлснээр дээрх бүсэд газар ашиглагч "Зүүнбаян рефайнери" ХХК тухайн үеийн Байгаль орчны сайдын 2008 оны наймдугаар сарын 22-ны өдрийн 283 тоот тушаалаар дөрвөн га газрыг аялал жуулчлалын зориулалтаар ашиглах эрх авч, газар ашиглах гурвалсан гэрээг мөн оны наймдугаар сарын 25-ны өдөр байгуулсан байна.

Улмаар эрх авч, гэрээ байгуулсны дараа зөөврийн сууц байрлуулан, хамгаалалтын хашаа барьжээ. Мөн тухайн үеийн ТХНУГ-ын /Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар/ дарга Т.Эрдэнэчимэг 2014 онд тус компанийн ашиглалтын талбайг голын хамгаалалтын бүсээс гаргах нэрээр талбайн солбицлын анхны байсан долоон цэгийг холбогдох тушаалгүйгээр 2014 оны дөрөвдүгээр сарын 23-нд 17 болгон өөрчилсөн байна. Өөрчлөгдсөн солбицол бүхий газар ашиглах гэрчилгээ, гурвалсан гэрээг Богдхан уулын дархан цаазат газрын Хамгаалалтын захиргаанд ирүүлээгүйгээс мэдээллийн зөрүүтэй байдал бий болсоор иржээ. Тэгвэл үүнтэй холбогдуулан хамгийн анх 2014 оны тавдугаар сарын 29-ний өдөр Хамгаалалтын захиргаанаас тухайн ашиглаж буй газарт хяналт шалгалт хийсэн байна. Гэтэл бургас мод сүйтгэсэн зөрчил илэрч 6.560.940 төгрөгийн торгууль, нөхөн төлбөрийг ногдуулж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 900013003 тоот дансанд төлүүлжээ. Түүний дараа 2016 оны есдүгээр сарын 19-ний өдөр мөн тухайн компанийн ашиглаж байгаа талбайд дахин хяналт шалгалт хийхэд бетон зуурмаг үйлдвэрлэх тоног төхөөрөмж байрлуулсан, бургас мод ихээр сүйтгэсэн зөрчлүүд дахин илэрсэн бөгөөд бетон зуурмагийн тоног төхөөрөмжийг нүүлгэх албан шаардлага хүргүүлсэн байдаг. Гэвч тус компанийн зүгээс улсын байцаагчийн албан шаардлагыг биелүүлэх боломжгүй байна гэсэн утгатай хариуг тухайн үед өгчээ. Гэх мэт байгальд их хэмжээний хохирол учруулсныг удаа дараагийн шалгалтаар тогтоож, өнгөрөгч тавдугаар 01-ний өдөр Нийслэлийн байгаль хамгаалах газартай хамтран огтлогдсон бургас, модны экологи-эдийн засгийн үнэлгээний дагуу "Зүүнбаян рефайнери" ХХК-д БОХУ-ын байцаагч Ойн тухай хуулийн дагуу дахин 12.363.420 төгрөгийн торгууль, нөхөн төлбөр ногдуулсан аж. Гэвч "Зүүн баян Рефайнери" ХХК-ийн байгальд учруулж байгаа хохирол, тус компанийн зөрчил, дутагдал одоог хүртэл арилахгүй байсаар байна. Иймд "Зүүнбаян рефайнери" ХХК-ийн талбайн хэмжээ хэтрүүлсэн, ДЦГ-ын нийтлэг горим зөрчсөн, байгаль орчныг сүйтгэж, унаган төрхийг алдагдуулж байгаа үйлдлийг таслан зогсоох, газар ашиглах эрхийг дуусгавар болгох шаардлагатай гэж үзэн БОАЖ-ын сайд Д.Оюунхорол тушаал гарган тус компанийн лицензийг цуцалжээ.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Газрыг зөвхөн газрын биржээр дамжуулан авч болно гэв

Нийслэлийн Засаг дарга С.Батболд өчигдөр цаг үеийн асуудлаар хэвлэлийн бага хурал хийлээ. Хэвлэлийн бага хуралд НЗДТГ-ын дарга М.Отгонбаяр, НЗДТГ-ын Хуулийн хэлтсийн дарга А.Даваажаргал нар оролцов. Хурлын эхэнд энэ сарын 20-нд УИХ-д өргөн барьсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар мэдээлэл өгөв. Тэрбээр "Энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр нийслэлийн удирдлагын нийслэлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг тодорхой болгож тусгасан байгаа. Улаанбаатар хот удирдлагын хувьд ямар байх, дагуул хот ямар төвшинд хөгжсөн байх ёстой, нийслэл хот, дүүрэг, хороо ямар чиг үүрэгтэй байх ёстой гэдгийг нарийвчлан тусгаж өгсөн. Нийслэлийн удирдлагууд шийдвэр гаргахдаа иргэдийнхээ санал дээр тулгуурлаж гаргана гэсэн хуулийн гол зохицуулалтыг тусгаж өгсөн байгаа. Дүүргүүдийг гүйцэтгэж байгаа үүргийн хувьд аймагтай харьцуулах маягаар авч явах нь зүйтэй гэсэн тодорхойлолтыг хуулийн төсөлд тусгаж өгсөн. Тухайлбал, нийслэлийн дүүргүүд 150-330 мянга орчим хүн амтай байхад аймгууд дунджаар 70-80 мянган хүн амтай байдаг. Дүүргийн хүргэж байгаа төрийн болон бусад үйлчилгээ 4-5 аймгийнхтай дүйцэхүйц байгаа учраас дүүргийн аймагтай харьцуулах маягаар бусад бүх асуудал дээр авч явах нь зүйтэй гэж хуулийн төсөлд тусгасан" гэв. Хуулийн төсөлд хэд хэдэн чухал асуудлыг оруулжээ. Тухайлбал, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Улаанбаатар хотод байгаа төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын менежментийг сайжруулах, хот өөрөө орлогоо олдог байх, хот өөрөө үнэт цаас гаргадаг байх зохицуулалтыг энэхүү хуулийн төсөлд тусгаж өгчээ. Мөн Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон тухай жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үнэ төлбөргүй, эсхүл давуу эрхээр, түүнчлэн төсөл шалгаруулах зарчмаар эзэмшүүлэхээр зааснаас бусад тохиолдолд газрыг зөвхөн газрын биржээр дамжуулан худалдана хэмээн заасан байна.

ШАР МЭДЭЭ

## Хуруунд тэмдэглэгээ хийх бэх дууссан гэнэ үү



АН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Х.Баттулгын сонгуулийн штабаас өчигдөр СЕХ-нд шаардлага хүргүүллээ. Уг шаардлагын агуулга нь сонгогчдод саналаа өгснийг нь илэрхийлэх хурууны бэхэн тэмдэглэгээ хийлгэх тухай аж. Энэ талаар АН-ын ЕНБД Ц.Туваан "Сонгогч олон удаа саналаа өгөх тохиолдол гарч болзошгүй гэж манай намын сонгуулийн штабаас үзэж байна. Сонгогчдын нэрсийн жагсаалтад сүүлийн үед нэлээд өөрчлөлт ороод байгаа зөрчлүүд ихэссээр байна. Ийм учраас бид СЕХ-нд шаардлага хүргүүлж байгаа юм. Мөн сонгуулийн санал хураах байруудад ажиллах ажиглагчдын бүхий л нөхцөл боломжоог хангаж бүрдүүлэх шаардлага тавьсан байгаа" гэж тодотгов. Энэ үеэр УИХ-ын гишүүн Я.Санжмятав "СЕХ хүлээсэн үүргийнхээ дагуу санал хураалтыг шударгаар зохион байгуулах ёстой. Сонгогчид дамжиж санал өгөх тохиолдол гарах өндөр магадлал байна. Тийм учраас хурууны тэмдэглэгээг зайлшгүй хийх хэрэгтэй гэж АН үзэж байгаа. Цаг хугацаа хангалттай байна, бэлтгэлийг хангаж амжина. Мөн бүх санал хураах байран дээрх саналын хуудсын 50 хувийг гараар тоолох шаардлага бас тавьж байгаа. Сурталчилгааны асуудал эрх тэгш биш байсаар байна. Сүүлийн үед АН-ын сонгуулийн сурталчилгааны материал тараах ажиллагаанд төрийн байгууллагууд саад учруулж, биднийг дэмжиж байгаа зарим ТББ-уудыг дарамтлах явдал ихэссээр байна" гэлээ. СЕХ-ны зүгээс бэхэн тэмдэглэгээ хийхэд шаардагдах бэх байхгүй гэсэн шалтгаан хэлж байгаа аж. Сонгуулийн тухай хуульд тэмдэглэгээ хийхэд шаардагдах бэхийг улсын төсөвт суутган авах асуудлыг маш тодорхой заож өгсөн бөгөөд СЕХ төсөвт суулгах эрхээ эдлэх учиртай гэдгийг АН-ын генсек онцолсон юм. Харин СЕХ үүнийг үгүйсгэв.

## Цахим системээр дамжуулан хуулийн төсөлд саналаа өгөх боломжийг танилцуулав

УИХ-ын Тамгын газар, "Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн" төрийн бус байгууллагаас өчигдөр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад зориулан "Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нөлөөллийг нэмэгдүүлэх нь" сэдэвт мэдээлэл өгөх уулзалтыг Төрийн ордонд зохион байгуулав. "Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн" төрийн бус байгууллага нь НҮБ-ын Ардчилал сангийн дэмжлэгтэйгээр УИХ-ын Тамгын газартай хамтран "Цахим засаглалаар дамжуулан хууль боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь" төслийг хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлсэн бөгөөд төслийн хүрээнд энэхүү уулзалтыг зохион байгуулсан юм.

Уулзалтаар хууль санаачлагчдын боловсруулсан хуулийн төслүүдэд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад сонирхлын бүлгүүдийн саналыг авах, нэгтгэх, тусгах, тухайн талуудад санал нь төсөлд хэрхэн туссан талаар эргэн тайлагнаж, харилцан мэдээлэл солилцоход зориулагдсан http://forum.parliament.mn цахим системийг танилцуулж, системийг хэрхэн ашиглах талаар хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад мэдээлэл өгөв. http://forum.parliament.mn цахим хэлэлцүүлгийн систем нь УИХ-ын http://parliament.mn/ цахим хуудасны дэд хуудас бөгөөд нэг талаас хууль тогтоох байгууллагад зориулсан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн саналыг авах, нөгөө талаас хуулийн төсөлд иргэд, олон нийт саналаа өгөх боломжийг хангасан, хууль санаачлагч ба олон нийтийг орон зай, цаг хугацаа, мөнгө санхүүгийн ямар нэг бэрхшээлгүйгээр холбосон талбар болохын хувьд хууль санаачлагч нь өөрийн санаачилсан хуулийн төслийг системд байршуулж, олон нийтийн хэлэлцүүлэг явуулахыг УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, технологийн хэлтсийн ахлах референт Ч.Тунгалаг хэлсэн. Одоогоор уг системд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан анхдугаар зөвлөлдөх санал асуулгын зөвлөмжийг үндэслэн боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг байршуулсан байгаа бөгөөд байршуулснаас хойших долоо хоногийн хугацаанд 1000 гаруй хүн үзэж, танилцжээ. Хэлэлцүүлгийн системийг ашиглаж эхэлснээсээ хойш 20 орчим хуулийн төслийг байршуулж, иргэд, олон нийтээс санал авсан бөгөөд Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 30 гаруй мянган хүн үзэж, 1000 орчим хүн саналаа өгсөн хэмээн "Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн" төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Ш.Оюунтуяа хэллээ. http://forum.parliament.mn цахим хэлэлцүүлгийн системээр иргэд хуулийн төсөлд саналаа өгөхөөс гадна хоорондоо харилцах, мэдээлэл солилцох, зөвшилцөж асуудлыг шийдвэрлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой юм.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

# ГУРАВХАН САЯ ХҮНИЙГ БҮРТГЭЖ ЧАДДАГГҮЙ ЮМ УУ, ХҮСЭХГҮЙ БАЙНА УУ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН




**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Өөрийн гэсэн үзэл бодолгүй, хэдхэн халтар төгрөгийн төлөө сонгох эрхээ худалдаж буй эдгээр хүмүүст түүнээс илүү гоё нэр өгөх хэрэг байхгүй билээ. Тэгвэл өнгөрсөн УИХ-ын сонгуулиар хутгасан бантан Ерөнхийлөгчийн сонгуультай зэрэгцэн дахиад л асуудал үүсгэж эхэлсэн бололтой. Уул нь 76 суудлын төлөө аймаг аймгаас сонголт хийх бус гуравхан хүний аль нэгийг Монгол Улс даяараа сонгох учраас царцааны хэрэг байхгүй баймаар.

> ...Тэгвэл одоо царцаа нараа цэгцлэх цаг нь болжээ, Р.Содхүү дарга аа. Өнгөрсөн долоо хоногоос эхлэн иргэдийн амьдардаг байр орон сууц, хашаа байшинд нэр зүсийг нь үл мэдэх бүстэй, бүсгүй хүмүүс нэмэгдсээр байгаа талаар иргэд өөр өөрсдийн чадах хэмжээнд мэдээллээ хуваалцаж байгаа. Бүр нэр дэвшигчид хүртэл энэ асуудлыг шалгуулах хүсэлтээ СЕХ-нд хүргүүлж байна. Оюуны өмч, улсын бүртгэл хэмээх том чухал салбарыг удирдаж суугаа Р.Содхүү энэ мэт тодорхойгүй асуудалд нэг мөр тайлбар өгч, царцаа цэгцлэх ажлыг сонгуулиас үл хамааран хийх учиртай бус уу...

Тиймээс УИХ-ын сонгуулийн "царцаа" нар бууриа олж чадахгүй ийн хоёр сонгууль дамжин дэвхэрч яваа бололтой. Ерөөс Монгол Улс иргэний бүртгэлийн асуудлаа эргэж харан, цэгцлэх цаг нь болчихож. Хаягийн бүртгэлийг шинээр хийж, айл өрх, иргэний бүртгэлээ эмхэнд нь оруулахгүй бол жил жилийн сонгуулиар ам бүл нэмэгдсэн хэрүүл үүсдэг болоод байна. Дан ганц сонгуулийн бүртгэл ч бус нас барсан иргэдийн тэтгэвэр, халамжийн мөнгийг банкны ажилтантай хуйвалдан авч байсан тохиолдол ч нэлээд олон удаа гарч байсан. Баян-Өлгий аймаг, Баянгол дүүрэг зэрэг газруудад ийм асуудал гарч, хохирлын хэмжээ хэдэн арван сая төгрөгөөр тоологдож байлаа. Мөн оршин суух хаяггүй иргэд ч халамжийн луйврын золиос болж байсан мэдээлэл цахим сайтуудаар дүүрэн байх аж. Халамж авсан ганц нэг ажилтан л зохих ёсны шийтгэлээ аваад өнгөрснөөс биш энэ гажуудлыг засах талаар төрийн бодлого огт хэрэгжээгүй. Нам солигдож энэ асуудлыг хэсэг хугацаанд улстөржүүлсэн ч өнөөдөр таг чиг болчихжээ. Цаашлаад хөдөө орон нутгаас шилжин ирсэн ах дүү амраг саднаа өөрийнхөө хаяг дээр бүртгэлжүүлж явсаар ам бүлийнх нь тоо 10 гарчихсан тохиолдол ч олон бий. Айл болгоны хаяг дээр 1-2 хүн бүртгэлтэй байдаг гэдгийг хэн ч мэднэ. Тэр тусмаа гэр хорооллын айл өрхүүдэд ийм асуудал олон байдаг талаар хорооны ажилчид ярьдаг юм билээ. Газрын гэрчилгээгээ авч ирээд ахыгаа, дүүгээ бүртгүүлнэ гээд суучихдаг учраас хуулийн дагуу бүртгээд явахаас өөр арга байдаггүй хэмээн ярьж байсан юм. Тэгвэл өнгөрсөн жил хотын дарга захирамж гаргаж хөдөө орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөнийг хязгаарлаж, тодорхой хэмжээний шалгууртай болгосноор энэ асуудал бага ч гэсэн цэгцэрсэн гэнэ лээ. Тэгвэл одоо царцаа нараа цэгцлэх цаг нь болжээ, Р.Содхүү дарга аа. Өнгөрсөн долоо хоногоос эхлэн иргэдийн амьдардаг байр орон сууц, хашаа байшинд нэр зүсийг нь үл мэдэх бүстэй, бүсгүй хүмүүс нэмэгдсээр байгаа талаар иргэд өөр өөрсдийн чадах хэмжээнд мэдээллээ хуваалцаж байгаа. Бүр нэр дэвшигчид хүртэл энэ асуудлыг шалгуулах хүсэлтээ СЕХ-нд хүргүүлж байна. Оюуны өмч, улсын бүртгэл хэмээх том чухал салбарыг удирдаж суугаа Р.Содхүү энэ мэт тодорхойгүй асуудалд нэг мөр тайлбар өгч, царцаа цэгцлэх ажлыг сонгуулиас үл хамааран хийх учиртай бус уу. Гэтэл Ерөнхийлөгчийн сонгууль эхэлснээс хойш энэ эрхэм гэгээн дүрээ нэг ч удаа харуулсангүй. Ерөөс ажлаа хүлээж авснаас хойш өөрийн байгууллагын үйл ажиллагаагаа нэг ч удаа олон нийтэд танилцуулаагүй гэхэд хилсдэхгүй. Осолдохгүй л нээлттэй хаалганы өдөрлөг хийж нэг өдөр л шуурхай ажилласныг эс тооцвол энэ байгууллагын үйл ажиллагаа хэвлэл мэдээлэлд хүртэл хаалттай хэвээр өнөөдрийг хүрч байна. Төрийн байгууллага хэрхэн ажиллаж байгаа, ямар ажил хийж эхэлсэн, хийж хэрэгжүүлсэн нь дөрөвдэгч засаглал болох хэвлэл мэдээллээр дамжиж иргэдэд хүрдэг гэдгийг эрхэм дарга болон түүний багийнханд сануулчихъя. Иргэний бүртгэлийн эмх замбараагүй асуудалд СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн гэхээс илүү Р.Содхүү дарга хариулт өгөх учиртай бус уу. Бүртгэлд яагаад маргаан үүсч буй, айлын хаяг дээр яагаад танихгүй иргэд олноор нэмэгдэж, амьдардаг хүмүүсийнх нь нэр алга болж орхисныг Р.Содхүү дарга та нэг сайн тайлбарлаад өгөөч. Эс бөгөөс элдэв янзын хардлага сэрдлэгэ нийгэмд үүсээд байна. Хурууны хээгээ уншуулаад санал өгчихдөг сонгуульд регистрийн дугаар, царцаа хоёр яагаад хэрэг болдгийг ойлгох ухаан хүрэхгүй нь. Бүртгэлтэй холбоотой энэ мэт маргааныг улстөржүүлэх хүсэл байхгүй ч дуугүй байх тусмаа илүү их хар төрүүлээд байгааг нуух юун. Гуравхан сая хүнийг бүртгэж чаддаггүй юм уу, хүсэхгүй байна уу.

Дугаарын **60** мөр

## Архины шил түймэр болдгийг мэдэх үү

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Дархан цаазат Богд ууланд байсхийгээд л их бага хэмжээгээр түймрийн гал улалзаж, хар модны гашуун хар утаа хоолой ам хорсгодог байдал энэ жил ч давтагдав. Гэм буруутай этгээд нь мэдээж самар хийгээд халиар түүгчид. Булган, Сэлэнгэ, Хөвсгөлийн уулархаг нутагт гарсан түймэр ч тэднээс үүдэлтэй. Самарчид эдүгээ ч уулнаас буугаагүй, самраа түүсэн хэвээр. Аягүй бол шинэ самартай залгах биз. Тэднийг байсхийгээд уулнаас албан хүчээр буулгах авч маргааш өглөө нь хөнжил, гудсаа үүрсэн самарчид хүний хөл хүрэхгүй, цагдаагийн машин явж чадахгүй аглаг тайгыг зорьж оддог. Амьдрал ядуугийн гай хэмээн тэднийг өршөөж болох ч эх орноо түймэрдсэн самарчдыг өршөөж үл болно. Хэдхэн өдрийн дараа сонгууль өндөрлөн, ялагдсан, ялсан улс төрийн хүчнүүд баярлах нь баярлаж, ялагдсан нь гунигаа тайлж байна гээд хаа нэг тийш архидахаар одох нь мэдээж. Үүнтэй зэрэгцээд аймаг, сумын наадам эхэлнэ. Улсын их баяр наадам ч залгана. Монголчууд намрын эхэн сарыг найрлаж өнгөрөөдөг заншлаараа нутаг ус, ижий аав гээд байгалийн үзэсгэлэнт газрыг зорих нь бий. Бас нэг хэсэг нь аялж таарна. Шулуухан хэлэхэд, та бид бүтэн сарын турш наргиж цэнгэнэ. Тийн аялахдаа нэг л зүйлийг анхаарна уу гэх байна.Тодруулж хэлбэл, та амарч зугаалахдаа байгаль орчинд эхийн сэтгэлээр хандаач гэх гэсэн юм.Авдар авдраар ачиж явсан хоол хүнснийхээ сав суулгыг буцаагаад машиндаа яагаад ачиж болохгүй гэж. Угаад хаясан шар айраг, ундаа, сокны шил хуурайшилттай үед түймэр болдгийг мэдэх үү. Ингэж хэлэхээр гайхах нэгэн таарч мэдэх л юм. Та бид хүүхэд байхдаа физикийн хичээлд үзсэнээ туршин нарны туяа ашиглан шилний хагархайгаар хуурай өвс ноцоодог байснаа санаж байна уу. Томруулдаг шилээр л гал гаргадаг бус уу гэж бүү эгдүүцээрэй. Шил бол шил шүү дээ. Гуу жалга, ойн цоорхой, голын эрэг дагуу хэдэн арваар нь хаяж орхисон архи, шар айраг, компот, сокны шил их үдийн наранд халахдаа дээр дурдсанчлан ойн түймэр гарах нөхцөл болдог байна. Ядаж байх нь ээ, энэ зун хур бороо ховор, хуурайшилт ихтэй байдаг. Ийм нөхцөлд ой хээрийн түймэр гарах магадлал хамгийн өндөр.

Байгаль дэлхий ангаж цанган хуурайшиж хатаж буй энэ цагт амралт зугаалгаар явахдаа уусан ундаа, амссан сархдынхаа шилийг аваад явах сэтгэлтэй байгаарай. Мөн дүрсгүй бяцхан үрсдээ энд тэнд, модны дор хаяж орхисон архины шилийг хагалж зугаацахгүй байхыг сануулах ч илүүдэхгүй биз.

Нийслэлийн иргэдийн явган аялал хийдэг хамгийн ойрын маршрут нь Богд Дүнжингарав. Даанч "алтыг нь аваад авдрыг нь хаях" атгаг хорон санаа хүний үрээс л гарах юм даа. Амьдарч буй орчноо аятай тааэтай байлгаж чадаагүйгээсээ болоод "боож үхэх"-дээ тулсан Улаанбаатарчууд хүчилтөрөгч хайж, хөлтэй нь хөлхөж, хөлгүй нь мөлхөх нь холгүй уул өөд мацаж байгаагаа маргаж мэлзэж чадахгүй биз. Ингэхдээ зүгээр явж чадахгүй уулын зам, ойн жим дагуулаад уусан ундааны сав, амссан сархдын шилээ хээв нэг шидэж байгаа харагддаг. Уг нь хэдхэн алхмын цаана байх хогийн сав руу түүнийгээ хийчихэд л болох юм. Сүүлийн үед "Би байгальд хог хаядаггүй" ч гэх балай балай чэйлэнж хийх болсон байна лээ. Хамгийн гол нь үг, үйлдэл хоёр чинь яв цав таардаг, зөв хүн байгаасай, залуус аа.

Үүнээс гадна уул ус тахих нэрээр лус савдаг хилэгнүүлдэг лам, бөө гэх мэт нөхдүүдэд зориудаар сануулах хэрэгтэй юм байна. Сан тавьж, арц уугиулахдаа анхаарал болгоомжтой байгаарай. Өнгөрсөн хавар, зуны заагаар гарсан түймрийн нэг нь иймэрхүү явдалаас улбаатай байсан шүү.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017 оны 06 дугаар сарын 22-ний өдөр.**

Тендер шалгаруулалтын нэр: [**Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Хөдөөгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон өргөн зурвасын сүлжээ байгуулах /Бүх сумд/" ажлын зураг төсөл боловсруулах, барилга усралтын ажил**]-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

Тендер шалгаруулалтын дугаар: **2017-ТГН010**

**Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар** нь эрх бүхий тендерт оролцогчдоос: **Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Хөдөөгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон өргөн зурвасын сүлжээ байгуулах /Бүх сумд/" ажлын зураг төсөл боловсруулах, барилга усралтын ажлыг гүйцэттэх** тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000,0 (Тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

- Сүүлийн 3 жилийн буюу 2014, 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байна.
- Сүүлийн 3 жилийн аль нэг жилийн хугацаанд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. Ажил гүйцэтгэх гэрээ, хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.

**Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай: Зураг төсөл боловсруулах байгууллага нь:**

**Б ангилал:** Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ

Төрөл:

- Гадна холбооны кабель, шугам угсралт, суурилуулалт, засвар
- Дотоод холбооны сүлжээний суурилуулалт, засвар
- Барилгын дотор холбооны монтаж, угсралт суурилуулалт
- Цамхаг түүн дээрхи холбооны тоног төхөөрөмж угсралт, суурилуулалт, засвар

3.2.1 0.4-10 КВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

**Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:**

1.2.2. 1-16 давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (ПОС, ПОР, ППР) зураг төсөл, Барилга байгууламжийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламж ( резервуар, бункер, силос, цамхаг, яндан, антенна гэх мэт)-ийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (ПОС, ПОР, ППР)

2.1.3. Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн, барилгын ажил (1- 16 давхар хүртэл), Цамхаг, тулгуур, түшиц хана, яндан, антенна зэрэг 30 м хүртэл өндөр угсармал ба цутгамал бетон, төмөр бетон, ган бүтээцтэй байгууламжийн ажил

Туншлэл болон туслан гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэх ажил үүргийн дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт дараах дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийн баталгааны дүн: **6,000,000 (Зургаан сая) төгрөг**

Тендерийг **2017 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 30- минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Залруулга:** "Монголын мэдээ" сонины 2017 оны 6 дугаар сар 21-ны өдрийн № 120 дугаартай сонин дээрхи зар нь огнооны хувьд буруу зарлагдсан тул 2017 оны 6 дугаар сар 22-ны өдөр дахин зарлаж байна.

**[Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг Нутгийн удирдлагын ордон 3-н давхар, Орон нутгийн өмчийн газар, 306 тоот өрөө (мэргэжилтэн С.Бат-Өлзий, Утас:70518123, 89151515)]**

# УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

# С.ОДОНТУЯА: Ардчиллынхан хийнэ л гэж амласан бол хийдэг

Н.ПУНЦАГБОЛД

Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшиж буй Х.Баттулга Улаанбаатар хотод ажиллаж байгаа билээ. Тэрбээр өчигдөр Баянгол дүүргийн иргэд, сонгогчидтой “Улаанбаатар палас”-т уулзаж, мөрийн хөтөлбөрөө танилцууллаа. Уулзалтад нэр дэвшигчээс гадна УИХ-ын гишүүн, АН-ын дарга С.Эрдэнэ, Нийслэлийн АН-ын дарга Д.Баттулга, Баянгол дүүргийн Засаг дарга, АН-ын дарга С.Одонтуяа, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл тэргүүтэй албаны хүмүүс оролцлоо. Уулзалтыг нээж Баянгол дүүргийн Засаг дарга болоод АН-ын дарга С.Одонтуяа “Улаанбаатар палас”-ыг дүүргэсэн дүүргийнхээ сонгогч, иргэдэд хандаж үг хэлсэн юм. Тэрбээр “Баянголчууд нэр дэвшигч Баттулгыг их л удаан хүлээлээ. Харин сүүлийн тэмээний ачаа хүнд гэдэгчлэн өнөөдөр бүтэн өдөр манай дүүрэгт ажиллаж, сонгогчдын уулзалтаас гадна худалдаа үйлчилгээний газруудаар явж, биенес эрхлэгчидтэй уулзах юм байна. Баянголчууд бид нэр дэвшигчээ сайхан мэдээтэй угтаж байгаа. Бид баянголчуудтайгаа уулзаж, судалгаа явуулсан. Олон төрлийн асуултад хариулт авч, бодит судалгаа хийсэн. Баянгол дүүргийн иргэд нэр дэвшигч Баттулгыг бүгд дэмжинэ гэдгээ илэрхийлсэн гэдгийг дуулгахад таатай байна. Иргэд сонгогчдоосоо бид тусгайлан асуусан. Та яагаад Баттулга нэр дэвшигчийг дэмжиж байгаа юм бэ гэж. Хүмүүс маш олон шалтгаан хэлж байна билээ. Гэхдээ дөрвөн үндсэн шалтгааныг иргэд түлхүү хэлж байна. Монголчууд бидний итгэл үнэмшил маш чухлаар тавигдах ёстой. 1990 оноос хойш сэргэж эхэлсэн монголчуудын итгэл үнэмшил улам бүр унтарсаар байгаа. Өөрийн гэх бизнестэй болоод, өөрийнхөө хүчээр амьдарна гэж итгэж байсан иргэдийн итгэл алга болсон гэж хүмүүс хэлж байна. Мөн төрийн албыг наймаалцагсад сонгуулийн үр дүнг луйврын аргаар өөрсдийн талд эргүүлэхээр оролдож буйд иргэд маш их дургүйцэж байгаа. Баялгийн тэгш хуваарилалт гэж алга гэдгийг бас иргэд хэлж байлаа. Бидний үнэт зүйл болсон эх орон, тусгаар тогтнол, шударга






ёсыг эрх баригчид нулимж байна гэж үзэх иргэд ч олон байна. Энэ бүхнийг өөрчлөх хүн нь Баттулга гэж Баянгол дүүргийн иргэд итгэж байгаа юм. Нөгөөтэйгүүр Баттулга нэр дэвшигч Монгол Улсаа эдийн засгийн хувьд тусгаар тогтносон, өрсөлдөх чадвартай болгоё хэмээн зорьж буй нь баянголчуудад туйлын их таалагдаж байгаа. Баттулга нэр дэвшигч бид хөгжинө, бид чадна гэсэн нийтийн итгэл үнэмшил өөрчлөлтийг авчрах хүч болж хувирдгийг мөрийн хөтөлбөртөө тод томруун бичсэн байна. Өнөөдөр монгол залуус эх оронч үзэлтэй, эрдэм боловсролтой, эрүүл чийрэг бие бялдартай, хариуцлагатай байх хэрэгтэй. Залуусыг ийм чадвартай болгохыг зорьж байгаагаа мөрийн хөтөлбөртөө багтааж өгсөн нь баянголчууд, ээжүүд биднийг Баттулга нэр дэвшигчид итгэх итгэлийг бий болгож байгаа



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

юм. Баянголчууд Ардчиллыг дэмждэг. Яагаад гэвэл Баянгол дүүрэгт Ардчиллынхан ялаагүй бол энэ олон бүтээн байгуулалт хийгдэхгүй байсан. Баянгол дүүрэгт ардчилал ялаагүй, Эрдэнэ гэдэг улстөрчийн баг байгаагүй бол энэ олон сургууль, цэцэрлэг баригдах байсан уу гэдгийг манай иргэдээс асууж болно оо. Та бүхэн мэдэж байгаа. МАН-ынхан Улаанбаатар хотыг 20 гаруй жил удирдсан. Тэд Улаанбаатарыг хамгийн бохирдолтой хот болгосон. Тэд Улаанбаатарыг хамгийн төлөвлөлтгүй хот болгосон. Байгаа бүх газрыг нь зарсан. Баянгол дүүрэг гэхэд л ямар төлөвлөлттэй байгааг бид бүхэн мэднэ. Харин өнгөрсөн дөрвөн жилд Бат-Үүл дарга гарч ирж байж нийслэлд ямар сайхан бүтээн байгуулалт хийснийг баянголчууд мэднэ. Ардчиллынхан хийнэ, бүтээнэ л гэсэн бол хийдэг” гэв. Харин УИХ-ын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлалын сайд асан Ц.Оюунгэрэл “ “Ардчилсан нам засаг барьж байхдаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг санаачлан батлуулж, “Дохионы хэл бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эх хэл мөн” хэмээн үзсэн. Тиймдээ ч манай нэр дэвшигч сонгогчидтойгоо уулзахдаа хүний эрхийг дээдлэн, дохионы хэлмэрч ажиллуулж байгаа билээ. Ингээд гол яриандаа оръё. Хэдхэн хоногийн дараа бид төр, түмнийг толгойлох тав дахь Ерөнхийлөгчөө сонгох гэж байна. Ерөнхийлөгч гэдэг шударга ёс, эв эеийн илэрхийлэл, ард түмний дуу хоолой байдаг. Харамсалтай нь, энэ удаагийн сонгуульд эрх баригч намаас нэр дэвшигчид ардчилал, хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөг улангаа гишгэн гутааж, элдэв гүжир гүтгэлгээр бөмбөгдөж байна. Түүнчлэн, төрийн алба, шүүх цагдаа, хэвлэлийнхнийг утсан хүүхэлдэй мэт болгожээ. Өнөөдөр эрх баригчдын хууль бус үйлдэл, амлалтаасаа ухарсан бодит үнэн хийгээд төр засгаа наймаалцсан талаархи баримт мэдээ мэдээллийг хоёрхон телевиз, хоёрхон сонин олон нийтэд түгээж, үнэний талд зогсч байна. Бусад нь яав. Хагас мянгаар тоологдох бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл яагаад хэт нэг талыг барин ажиллах болов. Ардчиллаас үнэ цэнэтэй юу байдаг болоод ийнхүү хаалтын гэрээгээр амаа таглуулчихав аа. Яагаад бүгдээрээ загас шиг дуугүй суунa вэ. Хоёр удаа дэмжиж гаргасан ардчилсан Ерөнхийлөгч маань юуны учир загас шиг дуугүй сууна вэ” гэсэн юм. Мөн Яруу найрагч Ц.Хулан Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулгыг дэмжихийг уриалаад зогсохгүй, эрх баригчид сонгуулийн үр дүнг хэрхэн луйвардахаар зэхэж байгааг ч баримттайгаар хэлсэн юм. Тэрбээр “Би та бүхэнд сонор сэрэмжтэй байгаарай гэж уриалсан. Тэгвэл эрх баригчид бүтэн жилийн өмнөөс сонгуулийн үр дүнг луйвардахаар бэлтгэж байсан баримт миний гар дээр байна. Миний сонгогчийн үнэмлэх манайд ирсэн. Манайх Баянгол дүүргийн 17 дугаар хорооны 17-гийн 24 тоотод байдаг. Гэтэл манай хаяган дээр Ц.Энхцэцэг, Т.Батбаяр гэдэг хоёр танихгүй хүн бүртгэгдчихсэн байна. Үүнийг манай хорооныхон мэдээд, танайд ийм хүн амьдардаг уу гэж асуусан. Би үгүй гэсэн. Гэтэл компьютерт нь бүртгэгдээд ороод ирчихсэн байна. Өөрөөр хэлбэл, энд ямар нэгэн “но” будилаан явж байна. Миний ханийн нэр алга. Гадаадад суралцаж байгаа хүүгийн маань нэр байхгүй байгаа. Тиймээс л би сонор сэрэмжтэй бай гээд байна” хэмээн хэллээ. Мөн тэрбээр хоосон улстөржиж, сүржигнээд байгаа юм биш шүү. Айл болгонд энэ мэтээр танихгүй хүн нэмж бүртгэж луйвардах гээд байна. Үүнийг хууль хүчний байгууллагынхан шалгамаар байна шүү. Тэд шалгахгүй бол ард түмэн бид шалгуулах бүрэн эрхтэй гэдгийг ч хэлсэн юм.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

# Энхболдууд амьдаагаа сонгох сэтгэлийн үүрэг тээж, ган дөрөөнд нь сүүн цацал өргөв



“Нэр нэгтийн чих нэг” гэдэг. “Энхболд оо” гэж дуудах агшинд 200 гаруй Энхболд нэгэн зэрэг эргэж харав. Учир нь, Монгол Улсын Ерөнхийлөгчид МАН-аас нэр дэвшигч М.Энхболд нэр нэгт “Амьдаа” нартайгаа уулзсан нь энэ. Монгол Улсад 5400 Энхболд нэртэй хүн бий. Тэдний нэг нь нэр дэвшигч М.Энхболд юм. Амьдаа нарын яриа ажил хэрэг гэхээсээ энгийн, нөхөрсөг байлаа. Тэдний халуун ярианы гол сэдэв нэрнийх нь учир. “Энх” гэдэг нь энхтайван амар амгаланг, “болд” гэдэг нь бат суурьтай, няцаж хугаршгүй гэсэн утгатай учраас Энхболдууд нэрийнхээ билэгшээлт учир утганд их дуртай төдийгүй нэр төрөө өндөрт өргөн явахыг эрхэмлэдэг гэнэ. Энхболд гэдэг ихэвчлэн эрэгтэй хүүхэддээ өгдөг нэр. Харин 5400 амьдаагаас 68 нь эмэгтэй гэнэ. Уулзалтад бүсгүйчүүдийн төлөөлөл ч ирж. Эцэг эх нь түүнд нэр өгөхдөө олон нэрнээс сугалахад Энхболд гэдэг нэр таарчээ. Хүүхэд байхад нь үеийнхэн нь түүнийг эрэгтэй хүүхдийн нэртэй энэ тэр гээд шоглоход ичдэг байж. Том болоод хэд хэдэн удаа нэрээ солих гэж оролдсон ч болоогүй гэнэ. Тиймээс Энхболд нэртэйгээ үлдээд аз жаргалтай сайхан амьдарч байна хэмээн инээх бүсгүйн сэтгэл нь хангалуун бүр, Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчтэй нэг нэртэй байгаадаа билэгшээн байлаа. Зургаан мянга шахам Энхболдын отгон нь нэг сартай нялх балчир хүү. Хожмын өдөр тэр хүү Ерөнхийлөгч болох ч юм билүү. Ерөөлөөр болог. М.Энхболдыг Хотын дарга байхад нь хамт ажиллаж байсан бас нэг Энхболд нэг удаа нэг баримт бичигт зэрэгцэж суугаад гарын үсэг зурж байсан дурсамжаа хуваалцлаа. Хүний амьдралд сонин тохиолдол олон бий. Тийм тохиолдол амьдаа нарт ч байна. Миеэгомбо овогтой Энхболд Монгол Улсад хоёр байдаг юм байна. Тэд ойролцоо насны идэрхэн эрчүүд. Нэг нь УИХ-ын дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч Миеэгомбын Энхболд бол, нөгөө нь Дундговь аймгийн иргэн, малчин Миеэгомбын Энхболд. Энэ хоёр хүний амьдралын хэв маяг, туулсан зам өөр. Гэхдээ тэдэнд ижил юм их байна. Овог нь, нэр нь нэг эрчүүд монгол морио дээдэлдэг, хурдан морины хорхойтнууд ажээ. Завтайхан үед адуун сүргийнхээ захад тухалбал хонон өнжин ярьсан ч амьдаагийн амьдаа Энхболдуудын морьдын тухай яриа хөөрөө дуусахгүй янзтай. Ерөнхийлөгчамьдаагаасаа жаахан бишүүрхэнгүй байсан малчин амьдаа нүүр хагарч, би тань шиг Миеэгомбын гэдэг овогоо, Энхболд гэдэг нэрээ өндөрт авч явж мал сүргээ улам олон болгоноо гээд нэр дэвшигч амьдаадаа шударга, тууштай төрийн тэргүүн болоорой гэсэн захиасыг дайж, хурдан удмын адуу бэлэглэв.

ЧӨЛӨӨТ СЭТГҮҮЛЧИЙН ИНДЭР

# ЭВИЙН ЦАВУУ МЭТ,СЭВИЙН БИЛҮҮ МЭТ ЭРХЭМ ЕРӨНХИЙЛӨГЧТЭЙ БОЛЦГООЁ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуульд АН-аас нэр дэвшигч Халтмаагийн Баттулгыг дэмжсэн түмэн ардын итгэл сэтгэлийн далайд дусал нэмэрлэхээр бодлын охь-бодит үгээ хэлье. Эрх баригч МАН-аас өөрийн нэр дэвшигч Миеэгомбын Энхболдыг газраас хийдүүлж, тэнгэрт тултал эх адаггүй магтахын зэрэгцээ өрсөлдөгчдөө, ялангуяа АН-аас нэр дэвшигч Х.Батулгыг санаанд багтамгүй, зүүдэнд оромгүйгээр гүжирдэн гүтгэж, нэр төрийг нь гутаан доромжилж, увайгүй хар пиараараа олон нийтийн сэтгэлийг булингартуулж байна. Коммунист угшилтай МАН сонгуульд бодлогоороо шударга өрсөлдөхийн оронд үнэмлэхүй эрх мэдлээрээ гул барьж, эрээгүй авирлаж буй нь ёстой л “харьсан бөх сурсан мэхээ үхэлдэн хийдэг”-ийн үлгэрийг санагдуулна. Эгэл амьдралын үнэн түүхийг нь магадалбал, Х.Баттулга Монголын ард түмний хайрт хүү, Монгол төрийнхөө алтан соёмбот далбааг дэлхийн спортын тэнгэрт мандуулж, сүлд дууллыг эгшиглүүлсэн гавьяат үйлстэн юм. Цонжин болдог, Нарны гүүр, Майдар төсөл, Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлын цогцолбор…юу эс вэ, энэ бүхэн Халтмаагийн Баттулгын нэрийн хуудас, түүний бүтээлч үүсгэлийн дээжис билээ. Тэрбээр ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путинээс дутуугүй самбоч-бөх бөгөөд АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трампаас өөрцгүй бизнесч-эдийн засагч болой. Ийм онцлог давуу чанар нь түүний сэтгэлийн хат, ухааны цэцийг харуулна. Хамгийн гол нь тэрбээр Монголыг дэлхийд алдаршуулж, дэлхийг Монголд айлсуулах аугаа мөрөөдөлтөн буюу. Тиймээс мөрөөдлөө биелүүлж, ард түмэндээ хоёргүй сэтгэлээр үйлчлэхээр Ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлж, чин шударгаар өрсөлдөж байгаа юм. МАН-ын гүтгэгчдийн бузар булай үйлдэл нь ”уутан доторх шөвөг” мэт илчлэгдэж, алтан нарыг алгаар хааж болдоггүйн адил Х.Баттулгын гэгээн үйлс ,амжилт бүтээл даяар олноо танигдаж, ”үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцэх”-ийн үлгэрийг давтаж байнам. Товчхон хэлбэл, Х.Баттулга нар зөв хүмүүн юм. Ийм хүн л Монгол төрийн алтан жолоог баривал зөв хэргийг зөвшөөрөн тэтгэж, буруу явдлыг буцаан залруулж, улс төрийн амьдралын тулгамдсан бэрхшээл, нийгмийн ээдрээтэй эмзэг асуудлыг “эвийн цавуу, сэвийн билүү” мэт зохицуулан шийдвэрлэж чадах нигууртай шүү дээ. Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Халтмаагийн Баттулгыг дэмжиж, нэрээр нь шүншиглэсэн ,шүлгэн цэцгээ өргөн барьсу.

**Б**аян дэлгэр нутаг шигээ өгөөмөр
**А**ян нүүдлийн отог шигээ өнөр
**Т**унгаамал алтан соёмбын сүүн цацалтай
**Т**үгээмэл гэгээн ардчиллын дуун хадагтай
**У**м сайны өлзий хутгийн абшигт
**Л**ам багштаны өлмий батын адистат
**Г**ажиг үйлдлийг гижиг хүртэл шоглож
**А**жиг дарах хасбуу төрийн **сартваахь** !

**СХД-ийн 19-р хорооны иргэн,**
**Сэтгүүлч Элжигин Лхүндэвийн Гомбожав**
**2017-6-18**

Õóí íü õóí áó?

# “Мон-Уран”-ы Б.НАРАНХҮҮ



**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

## Сөрөг мэдээлэл нь давамгайлах Б.Наранхүү

“Мон-Уран” ХХК УИХ-ын гишүүн Б.Наранхүүгийн овог нь болжээ. Яг үнэнийг хэлэхэд Батсүхийн, Дундговийн, Наран хээрийн, Дүнжингаравын , УИХ-ын гишүүн гэх тодотголуудын аль нь ч түүнд наалдаж өгдөггүй юм. Тэр бүү хэл, УИХ-д Батсүхийн Наранхүү гэдэг гишүүн байдаг уу хэмээн эгэл ардаас асуувал тун цөөхөн нь байдаг гэж дуулдсан, одоо бий билүү гэж хариулж мэднэ. Үнэндээ ч тэрбээр 2012-2016 онд чуулганы нэгдсэн хуралдаанд тун цөөн харагдсан. Энэ удаад ч ялгаагүй, хамгийн их тасалсан, чөлөө авсан гишүүдийн нэгээр тодорсон. Өөрт нь хуулийн төсөл санаачилж сүйд болдоггүй юм аа гэхэд ажлын хэсэгт болов орж ажиллан гишүүнийхээ үүргийг гүйцэтгэе гэх хүсэл тэмүүлэл байдаггүй бололтойдог. Тэгвэл яах гэж УИХ-д суудаг юм гэх хэн нэгний ёозгүй асуултад мань хүн “ УИХ надаар дутахгүй. Мэргэшсэн хуульчид нь хуулиа боловсруулаг л дээ. Би тэнд суудал бөглөж сууснаас тойргоо тойглож байсан нь дээр” хэмээн хэнэг ч үгүй хариулсан талаар тухайн үед хэвлэлүүд хэсэг шуугисан. Тэгэхээр мань хүний төр түшилцэж байгаагийн цаад мөн чанар хувийн өмчид нь хэн нэгэн халдах эрсдлээс хамгаалахад оршдог байж ч мэднэ. Энэ нь 2015 онд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Паркийн газрыг буцааж өгөх асуудлыг хэлэлцэхэд тэрбээр “манай компани” хэмээн суудлаасаа өндөлзөж байснаас нь харагддаг. Ер нь Б.Наранхүү гэж юм бэ. Түүний тухай мэдэж авахаар интернет ухах аваас Улсын их баяр наадмаар морь нь айрагдсан, түрүүлсэн гэхээс бусдаар дандаа л сөрөг голдуу мэдээлэл байх аж. Ийм нэг эрхэм ганц мандаттай Дундговь аймгийн иргэд сонгогчдыг УИХ-д төлөөлдөг. Өмнө нь УИХ-ын гишүүн Ж.Наранцацралт агсан энэ аймгаас сонгогдож байсан юм. Ардчилалд ээлтэй дундговьчууд хоёронтоо итгэл хүлээлгэн УИХ-д мань эрийг илгээхийг бодоход тойргоо боломжийн хэмжээнд усалж тордоод байдаг юм байлгүй.

## Гэнэт тодорсон улстөрч

Тэрбээр бүрэн дунд боловсролтой. Тодруулж хэлбэл, Ерөнхийболовсролынаравдугаар анги төгссөн гэрчилгээнээс өөрөөр хүнд үзүүлэх юмгүй гэсэн үг. Уг нь МУИС-д урилгаар элсэн хэдий ч гуравдугаар курсээсээ сургуулиа орхисон байдаг. Юуны учир сургуулиа орхисон талаар сонирхох аваас амьдралд, эхнэр хүүхэддээ хайртай эр хүний хийсэн сонголт байх вий. Б.Наранхүүгийн улс төрд хөл тавьсан түүх бизнест амжилт олсноос нь илүү сонирхолтой. Тэрбээр Монголын нэр нөлөө бүхий хоёр улстөрчийн нөмөр нөөлөгт багтаж явсан азтай эр. Оюутан ахуйдаа УИХ-ын дарга асан Р.Гончигдоржийн / Гончигдорж тэр үед МУИС-д багшилж байсан хэрэг/ гэрт амьдарч тэдний халуун ам бүлийн тоонд багтаж явсан бол ажил амьдралын захтай болсон хойноо Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдын жолоочоор ажиллаж, түүнтэй шадарлаж явсан удаатай. Харамсалтай нь мань хүн даргынхаа газрын наймааг зурагтаар илчилсэн гэмтэй. Өдгөө тэдний харьцаа ямар төвшинд байдгийг бурхан мэдэх байх. Харин яруу найрагч тухай Ц.Хулан эл үйлдлийнх нь талаар “Ардчилал гээч энэ юм” хэмээн нэгэн нийтлэлдээ онцолсон байна лээ. Өнгөц дүгнэхэд хүн чанаргүй харагдах эл үйлдлийнхээ талаар тэрбээр хожмын өдөр дурсамждаа өгүүлэх биз. Тэгэхээр түүнд Р.Гончигдорж нөлөөлсөн болж таарч байгаа юм. Магадгүй 2012 онд Дундговь аймгаас нэр дэвшихийг нь ч зөвлөсөн байхыг үгүйсгэх аргагүй. Ер нь Б.Наранхүү улс төрд гэнэт л гарч ирсэн нөхөр. Цаг үе нь түүнд тийм боломжийг олгосон хэрэг. Эдүгээ АН доторхи “Нэг ардчилал”-д багтдаг. Гэхдээ сүүлийн үед “Шонхор” фракцийнхантай тун чиг дотно болсон гэх мэдээлэл чих дэлсэх болоод байгаа.

## Тойргоо хөгжлөөр бус мөнгөөр усалдаг түшээ

Дундговь хөгжлөөрөө хоцрогдсон аймгийн нэг. Төв аймгийн өмнө бичигддэг шүү дээ. Өнгөрсөн хавар тойргоор нь дайраад өнгөрсөн. Аймгийнхаа хойд талд залсан Морин хуур нь өгөрших тийшээгээ хандсан байсан бол урд талд байгуулсан хурдан морины хөшөө бүхий цогцолбор нь өчигдөр ашиглалтад хүлээлгэж өгсөн юм шиг л гялалзаж байх жишээний. Дундговьчууд хол ойрын зочдоо Наранхүүгийнхээ ресторанд хүлээн авдаг юм билээ. Хөрөнгө оруулалтын тал дээр боломжийн зүйлүүдийг буй болгосныг энд онцлон тэмдэглэх ёстой. Залуучуудын боловсролд ач холбогдол өгч тэд өөрсдөө ажлын байраа бий болгох тухайд анхаарал хандуулсныг шинээр баригдаж, ашиглалтад орсон Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа хэлээд өгөх байх. Мөн Монголд тун цөөн байж мэдэх бүрэн тоноглол бүхий хувийн ерөнхий боловсролын сургуулийг ашиглалтад оруулжээ. Энэ бүхэн Наранхүү гишүүний орон нутагтаа хийсэн хамгийн том хөрөнгө оруулалт байж мэднэ. Бас аймгийн төв доторхи засмал замыг нэрлэх учиртай. Эдүгээ социализмын үед баригдсан гурван давхар хэдэн цагаан тоосгон орон сууцаа шинэчилж, АН-ын гишүүний хувьд гэр хорооллын дахин төлөвлөлтийг амжилттай үргэлжлүүлж чадвал дундговьчууд түүнд дахин итгэл хүлээлгэх нь гарцаагүй. Харин түүнийг сонгогчиддоо хэр ойр байдаг, тэднийхээ үгийг сонсдог тухайд хэлж мэдэхгүй нь. Иргэдийнх нь ярьж байснаар бол УИХ-ын сонгууль ойртмоц мань хүн оюутан залуучуудыг цуглуулан сүлд модны наадам зохион байгуулж, хурдан морины уяачдыг ивээн тэтгэж, морь нь түрүүлэх аваас “Land-200” бэлэглэж, тэднийг өөртөө татдаг гэнэ. Өөрөө ч хурдан моринд ухаанаа тавих нь бий. Удам угшил сайтай хурдан моринд, хүч сайтай төмөр хүлэгт гар татаж үзээгүй нэгэн. Тэрбээр тус бүр нь 300 мянган ам.долларын үнэтэй “Rolls-Royse” маркийн авто машин дөрвийг 2011 онд худалдаж авч олны амыг ангайлгаж байлаа. Тэдгээр төмөр хүлгүүд нь 8668 гэсэн адилхан дугаартай гэж байгаа. Хамгийн сүүлд өнгөрсөн хавар 500 мянган ам.доллараар машин худалдаж авсан гэж дуулдсан.

## Хувьдаа 23 аж ахуйн нэгжтэй эрхэм

**Товч намтар:**
**Ажилласан байдал**

“Мон-Уран” ХХК-ийн ерөнхий захирал 1999 - 2012 онд

“Инвэкс” ХХК-ий ерөнхий захирал 2005 - 2012 онд

“Дүнжингарав” ХХК-ий ерөнхий захирал 2008 - 2012 онд

Монгол Улсын Их Хурлын гишүүн 2012 оноос

**Хөрөнгө орлогын мэдүүлэг:**

**Үл хөдлөх хөрөнгө:** Орон сууц-2 /1 000 000 000 төгрөг/

**Автомашин:** Land Rover Range Rover -1, Land cruiser Standart-1, Rollsroyce Phantom-3 /1 185 000 000 төгрөг/

**Хадгаламж:** 21 195 800 000 төгрөг

**Эзэмшдэг компани:** “Дүнжингарав” ХХК-ий 34 хувь, “Инвэкс” ХХК 100 хувь, “Монголын Уул уурхайн корпораци” ХХК 100 хувь, “Мон- Уран” ХХК 100 хувь, “Дүнжингарав Констракшн” ХХК 100 хувь, “Инвэкс Жювелри” ХХК 100 хувь,” Инвэкс мэншоп” ХХК 100 хувь, “Инвэкс Хоум” ХХК 100 хувь, “Инвэкс Коммодитис” ХХК 100 хувь,” Инвэкс спортс” ХХК 100 хувь, “Инвэкс Кантийн” ХХК 100 хувь, “Инвэкс Шүүз” ХХК 100 хувь,” Инвэкс Сервис” ХХК 100 хувь, “Инвэкс Лэдишоп” ХХК 100 хувь, “Инвэкс Бэйбишоп” ХХК 100 хувь, “Хүлэрхэрд” ХХК 100 хувь, “Дүнжингарав тээвэр” ХХК 100 хувь, “Дүнжингарав роуд” ХХК 100 хувь, “Дүнжингарав секьюрити” ХХК 100 хувь, “Монголмедиа консорциум” ХХК 100 хувь,” Оргил энд Капитал партнерс” ХХК 100 хувь,” Дүнжингарав трейд” ХХК 100 хувь, “Шинэ зуун айл зах” ХХК 100 хувь,” Шинэ зуун айл трейд” ХХК гэсэн 23 аж ахуйн нэгжийн хувьцааг зуун хувь эзэмшиж, Дүнжингарав ХХК-ий 34 хувийг эзэмшдэг гэхээр хөрөнгө бэлийн хувьд түүний өмнө гишгэх тэрбумтан Монголд бараг л байхгүй болов уу.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

# ЧУХАЛ ХҮН

## Аймгаас мэдээлж байна

ДАРХАН-УУЛ АЙМАГ

### Дархан-Уул аймгийн наадмын комисс хуралдлаа

Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний баяр наадмыг Дархан-Уул аймагт 09, 10, 11-нд зохион байгуулахтай холбогдуулан Баяр наадмын комисс хуралдлаа. Хурлаар наадмын үеэр зохион байгуулах ажлаа ярилцахын зэрэгцээ есөн салбар хороог байгуулсан юм. Үүнд Үндэсний бөхийн барилдааны салбар хороо, Морин уралдааны салбар хороо, Үндэсний сурын харвааны салбар хороо, Шагайн харвааны салбар хороо, Тохижилт, реклам чимэглэлийн салбар хороо, Ёслол хүндэтгэл баяр наадмын нээлт, хаалт, урлаг спортын ажлын хэсэг, Худалдаа үйлчилгээний ажлын хэсэг, Үйлчилгээ аж ахуйн ажлын хэсэг, Хэв журам сахиулах ажлын хэсэг гээд нийт есөн салбар хороо байгуулагдлаа. Баяр наадмын арга хэмжээнд хамтран ажиллах иргэн, иргэний нийгмийн байгууллага, ТББ-ын саналыг 7037-1212 утсаар авч байна.

СЭЛЭНГЭ АЙМАГ

### 66 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлжээ

Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйлдвэрлэж байгаа цус, цусан бүтээгдэхүүний хэмжээ жил бүр харилцан адилгүй байдаг байна. Тус аймгийн Цусны салбар төвд 2016 оны байдлаар 82.8 литр цус үйлдвэрлэж, үүнээс эмнэлэгт олгогдсон нь 64.3 литр байжээ. Харин өмнөх таван жилийн байдлыг харьцуулж үзэхэд 2014 онд нийт 104.5 литр цус үйлдвэрлэж эмнэлэгт 89.9 литрийг ашигласан нь бусад онуудтайгаа харьцуулахад илүү байгаа юм. Энэ нь тухайн жилийн онцлог, хүмүүсийн өвчлөл, цусны хэрэгцээнээс хамардаг аж. Тэгвэл Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн Цусны салбар төв нь анх 1972 онд Цусны станц нэртэйгээр ажил үйлчилгээгээ эхэлж байсан бол эдүгээ Цусны салбар төв болон өргөжжээ. Тус төвийн тухайд өнгөрсөн 2016 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн хүрээнд нийт 66 нэр төрөл бүхий 364.3 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна. Түүнчлэн цусны албаны эмч, мэргэжилтнүүд мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх найман удаагийн богино хугацааны сургалтад хамрагдаж чадсан аж. Эдгээрээс гадна байрны засвар үйлчилгээнд зориулан 22.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Өнөөдрийн байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд цусны донор бүхий 665 иргэн байгаагийн 252 нь Сүхбаатар суманд, 413 нь бусад сумдад амьдарч, иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө авлагагүй донорын үүргийг сайн дураараа гүйцэтгэдэг байна.

ДОРНОГОВЬ АЙМАГ

### Эрчим хүчний байнгын эх үүсвэрт холбогдлоо



Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Эдийн засаг, нийгмийг 2017 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан Оюу толгой-Цагаан суварга чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцыг барих ажил дуусчээ. Энэхүү ажлыг “МАК” компани өөрийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж, энэ сарын 19-нд Дорноговь аймгийн удирдлагуудад хүлээлгэн өгчээ. Оюу толгой-Цагаан суварга чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станц ашиглалтад орсноор Хатанбулаг, Мандах сумд байнгын эрчим хүчээр хангагдаж, төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдож байгаа аж. Мандах, Хатанбулаг сумдын эрчим хүчний байнгын эх үүсвэрт холбох ёслолын ажиллагаанд УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, Г.Мөнхцэцэг, Эрчим хүчний сайд П.Ганхүү, “Мак ХХК”-ийн ТУЗ-ын дарга Б.Нямтайшир, Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, БЗӨБЦТС ТӨХК-ийн дарга Н.Тавинбэх, сумдын удирдлагууд болон ард иргэд оролцжээ.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

### Хөдөлмөр, халамжийн үйлчилгээг нэг дороос авчээ

Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Уул уурхайн жишиг Политехник коллеж, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран энэ сарын 19-нд “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулжээ. Өдөрлөгийн нээлтийн үйл ажиллагаанд тус аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Уранцэцэг, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Д.Гансүх, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Аюушжав, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Ц.Оюунбилэг болон бусад албаны хүмүүс оролцсон байна. Өдөрлөгийн үеэр Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төсөл хөтөлбөрийг дэмжлэг авсан иргэдийн үзэсгэлэн худалдаа, Нийгмийн халамжийн бүх төрлийн үйлчилгээ, Хөдөлмөрийн харилцаатай холбоотой хууль тогтоомжийн танилцуулга, хууль тогтоомжийн хүрэнд хийж буй ажлын талаар иргэдэд танилцууллаа. Мөн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс эрүүл мэндийн даатгалын, нийгмийн даатгалын дэвтэр олгох, Эмнэлэг, эмийн сангийн үйлчилгээ, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох иргэдийн материалыг шалгаж зөвлөгөө өгч ажиллажээ. Түүнчлэн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь Хүүхэд хамгааллын тухай хууль, 2017 онд шинэчлэгдэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг сурталчлах, Мэргэжлийн сэтгэл зүйч иргэдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, хамтарсан багийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулсан байна.

# Л.Дүгэржав: АНТАРКТИДАД ХАДААЖ МӨС ХАЙЛА

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

-Би Тэсийн голын хүүхэд. Тэртээ 60 жилийн өмнө дүн өвлөөр буюу нэгдүгээр сарын найманд Увс аймгийн Тэс суманд төрсөн. “Тэсийн голын унага, Тэрхийн голын хүүхэн” гэдэг биз дээ. Гэхдээ зургаахан сартайдаа дутуу төрсөн юм билээ. Миний аав ээж тайж гаралтай. Аав минь хошуу ноёны ач хүү. Би эцэг эхээс 16-уул. Би айлын 10 дахь хүү. Намайг “За, энэ хүн болохгүй нь дээ” гэж бодож байсан гэнэ лээ. Тэгээд аавын малгайнд багтаад нарны аяс дагаад хананы толгой дамжсаар Майн баяр буюу тавдугаар сарын нэгэн болсон чинь “За, энэ хүн болох юм байна. Арай өнгөрчихгүй нь” гэсэн итгэл төрж миний зургийг авахуулсан байдаг. Би аав ээждээ баярлаж явдаг. Тэсийн гол зундаа +50, өвөлдөө -50 градус байдаг юм шүү дээ. Монголоос Антарктид тивд хүрсэн эхний дөрвөн хүн дөрвүүлээ Тэсийн голын хөвөөнд төрж өсөцгөөсөн байдаг юм. Ж.Цэрэндэлэг, Хөвсгөлийн Д.Чулуунбат /Тэсийн голын эх хэсэг тэнд бий/, тэгээд А.Батболд бид хэд байна. Ж.Цэрэндэлэг гуайн үг бий. “Хэр зэрэг хүйтэн юм бэ” гэж асуухад “Аа, манай Тэсийн гол шиг л байдаг юм байна” гэж хариулсан байдаг байхгүй юу.

**-Таны анхны мэргэжил газрын тосны инженер гэхээр бас л газрын хэвлийтэй холбогдож байна шүү дээ?**

-Тэсдээ наймдугаар анги, Улаангомд аравдугаар анги төгсөөд Болгарт газрын тосны өрөмдлөг, олборлолтын инженер гэсэн хуваарь авч суралцсан. Өрөмдлөг, геологийн инженер гэдэг чинь өргөн утгатай, олон шинжлэх ухааны дунд байж байдаг. Геологи, хайгуул, нефть, цэвдэг, техник, технологи, эдгээрийг чинь бүгдийг уялдуулж болдог нь өрөмдлөг юм. Өөрөөр хэлбэл, газрын дор барьж байгуулж буй барилга байгууламж байхгүй юу. Хаана ч очсон газрын гүнийхээ өрөмдлөг, судалгааг хийхгүйгээр судалгааны ажил хийх ойлголт байдаггүй. Тэр тусмаа хамгийн үнэтэй судалгааны ажил нь энэ байдаг юм. Антарктид тивд өчнөөн судалгааны ажлыг хийчихсэн, хүмүүс. Орос, Америк хоёр өрөмдөж байна. Би өрмийн инженер хүн учраас азтай. Намайг дагаад өрмийн инженер мэргэжилтэй дөрвөн монгол залуу очсон. Тэд геологи, ус, цаг уураар мэргэшсэн залуучууд. Бид одоо газрын гүн рүү нэвтэрч орох боломжтой. Яагаад бид Антарктид тив рүү яваад байна вэ гэвэл хүн төрөлхтөн нэг л дэлхийтэй. Чиний толгой өвдөнө үү, зүрх өвдөнө үү, хөл өвдөнө үү хамаагүй нэг л амьд бодьгал шүү дээ. Үүнтэй л адил зүйл өнөөдөр хүн төрөлхтөнд тохиолдож байна. Би саяхан “Дэлхийн дулаарал Монголд нөлөөлөх нь” сэдвээр илтгэл тавьсан. Яагаад дэлхийн дулаарал Монголд нөлөөлж байна вэ. Бидэнд ямар давуу тал, мөн ямар дутагдал байгаа юм бэ. Энэ амьд байгаль дотор амьдарч яваа монголчууд өөрийн гэсэн орон зайгаа зөв авч явж чадвал Монгол гэдэг нэр үргэлж л өөдөө явах ёстой юм.

> ...Өнөөдөр “Улсын начин болоход тэдэн сая төгрөг хэрэгтэй гэнэ” гээд л яриад байдаг. Тэгвэл нэг улсын начны зардлаар нэг жилийн хугацаатай экспедиц ажиллуулж, 4-5 монгол хүнийг тэнд аваачиж болно. Шинжлэх ухааныг үнэлж, Монгол Улсын нэр хүндийг өргөх асуудалд төр нэгийг бодох л ёстой болов уу. Монголчууд тамирчид бөхчүүдийнхээ бяр чадал, хүч хөдөлмөр, урлагийнхны авьяас чадварыг үнэлж, ойлгодог болжээ...

**-“Антарктид тивд очих юмсан” гэдэг хүсэл сонирхол таны мөрөөдлийн учигт сүүмэлзэж эхэлсэн нь хэдий үеэс вэ. Ямар гаргалгаа, тойрог төөргөөр явж байж та энэ боломжоос атгаж авав?**

-Монгол орны цэвдгийн хил улам бүр хойшилж байгаа. Манай дэлхийн цэвдгийн хамгийн урд талын хил Монголоор буюу тал хээр, Алтай, Хангай, Хэнтийн уулсаар өнгөрдөг юм. Энэ нь одоо улам хойшилсоор байна. Дахиад 10 жилийн дараа Монгол орны цэвдгийн зураг дээрээс маш олон цэнхэр өнгө алга болно. Би 1991 онд “Монгол орны цэвдгийн доорхи усны судалгаа” гэдэг сэдвээр эрдмийн зэрэг хамгаалж доктор болсон. Энэ бүхэн л надад дэлхийн дулаарал гэдэг зүйлийг судлах боломжийг олгосон юм. Монгол Улс бол дэлхийн нэг хэсэг шүү дээ. Дэлхийн хуурай газрын нэг хувь нь юм. Эмч нар миний яриаг сайн ойлгоно. Хүний өрөөсөн хуруу байхгүй болоход бие махбодид өөрчлөлт орж байдаг. Дэлхийн дулаарал гэдэг үүнтэй адилхан. Миний судалгааны ажлыг мэддэг учраас найз болгаруудынхаа дэмээр дөрвөн удаа Болгарын экспедицийн бүрэлдэхүүнд орж явлаа. Мөн олон улсын экспедицийн бүрэлдэхүүнд орж Өмнөд туйлд хүрсэн анхны монгол хүн болсон. Би түүндээ баярлаж явдаг. Миний нэрээр нэрлэгдсэн “Dugerjav peak” гэдэг оргил Антарктид тивд бий. Монгол Улсынхаа төлөө, үр хойчийнхоо төлөө хийсэн гавьяа минь энэ гэж би хувьдаа боддог. Бүхэл бүтэн экспедиц зохион байгуулах хэмжээнд хүрсэн. Манай Антарктид судлалын төв гэхэд 40 орчим гишүүнтэй. Түүнээс Антарктид явсан залуучууд маань бүгд докторын зэрэг хамгаалсан. Физик, математик, геологи, минериологи, газар зүйн ухаанаар. Одоо дараагийн ээлжийнх нь хүмүүс бэлтгэгдэж байгаа. Манайхан Антарктид очно оо очно. Яагаад гэвэл, тэр хүйтэн, эрс тэс нөхцөлд монголчууд хамгийн түрүүнд адаптаци /организм орчиндоо зохилдохыг ингэж хэлдэг/-д орж чаддаг. Тиймээс монголчууд хамгийн эхэлж тэнд соёл түгээгээсэй гэж хүсч байна. “Уяхан замбативийн наран”-г хадааж мөс хагарч байхыг үзээсэй. Монгол орны цаг уурын өөрчлөлт дэлхийн цаг уурын өөрчлөлтийн


## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны дахин төлөвлөлтийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах” ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

**Үүнд:**

**Багц-1** Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо 72 дугаар хотхон орчмын ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төслийн ажил / ШИНЭ ГЭР ТҮНШЛЭЛ ХХК 6, 7, 8 дугаар байр/

**Багц-2** Баянгол дүүргийн 1 дүгээр хороо ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төслийн ажил / ТЭРГҮҮН ЧАНСАА ХХК 17, 18, 20 дугаар байр/

**Багц-3** Баянгол дүүргийн 1 дүгээр хороо ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төслийн ажил / АЛТАН ТРЕЙД ХХК 13, 14, 15, 16 дугаар байр/

**Багц-4** Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо 72 дугаар хотхон орчмын ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төслийн ажил / МЕТАЛЛ энд ВҮҮД ХХК 5, 16, 24 дүгээр байр/

**Багц-5** Ашиглалтын шаардлага хангахгүй Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны 53, 54 дүгээр байрыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төслийн ажил

**Багц-6** Ашиглалтын шаардлага хангахгүй Баянгол дүүргийн 2 дугаар хороо, Есөн шар СӨХ-ны харьяалалд байдаг 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34 дүгээр байрыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төслийн ажил

**Багц-7** Ашиглалтын шаардлага хангахгүй Налайх дүүргийн 2 дугаар хороо, 4, 5 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төслийн ажил

**Багц-8** Ашиглалтын шаардлага хангахгүй Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны Нисэхийн 34, 35 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төслийн ажил

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас 2017 онд хийгдэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ:

- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- Тусгай зөвшөөрлийн хуулбар

**Барилга хот байгуулалтын яамны:**

1.2.4 Дотор усан хангамж, ариутгах, татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох байгууламжийн технологийн зураг төсөл

1.2.5 Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл ). Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл. Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

1.3.1 Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг

1.3.2 Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

1.3.3 Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /35 кВ хүртэл/ эсвэл түүнээс дээш заалт

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

*Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 08:00 цагаас 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 17:00 цаг хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 07 дугаар сарын 05–ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү.*

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,**
**Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,**
**Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар,**
**Утас: 75757807**
**Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn**

ЧУХАЛ ХҮН

# Д "УЯХАН ЗАМБАТИВИЙН НАРАН"-ГАА ХЫГ ХАРАХ НЬ МИНИЙ МӨРӨӨДӨЛ



нэг барометр шүү гэдгийг ойлгож дэлхийн хэмжээний олон улсын төсөл хөтөлбөрт оролцдог, үүнийг манай улсын Засгийн газар ойлгож дэмждэг байгаасай гэж хүсдэг. Энэ бол шинжлэх ухаан. Эргээд амьдралтай холбогддог юм шүү. Хүссэн, хүсээгүй монголчуудад төдийгүй хүн төрөлхтөнд хэрэгтэй зүйл. Тиймээс удирдах дээд төвшиндөө дэмжих хэрэгтэй байгаа юм. Дэмжлэггүй л бол уначихна. Бид одоохондоо явж л байна. Гэхдээ сая сая, тэрбум тэрбум ам.доллараар үнэлэгддэг ажил шүү дээ. Өнөөдөр "Улсын начин болоход тэдэн сая төгрөг хэрэгтэй гэнэ" гээд л яриад байдаг. Тэгвэл нэг улсын начны зардлаар жилийн хугацаатай экспедиц ажиллуулж, 4-5 монгол хүнийг тэнд аваачиж болно. Шинжлэх ухааныг үнэлж, Монгол Улсын нэр хүндийг өргөх асуудал. Төр нэгийг бодох л ёстой болов уу. Монголчууд тамирчид бөхчүүдийнхээ бяр чадал, хүч хөдөлмөр, урлагийнхны авьяас чадварыг үнэлж, ойлгодог болжээ. Харин одоо шинжлэх ухааныг ойлгож оюуны бядыг дэмжих хэрэгтэй. Ингэж байж л Монгол Улс хөгжинө.

**-Антарктид тивд "зочлоод" ирсэн хүмүүсийн үлгэр домог шиг яриаг сонсч төсөөлөл хуримтлуулах, анх хөл тавих хоёрын хооронд ялгаа зөрүү нь юу байв. Энэ бүхэн чинь л түүх болж үлдэнэ шүү дээ?**

-Социализмын үед буюу 70, 80-аад оны үед Ж.Цэрэндэлэг, Д.Чулуунбат гуай хоёр явсан. Тэр үед дэд бүтэц хөгжөөгүй байсан юм. Тэр хүмүүс хэчнээн мундаг Зөвлөлтийн экспедицийн бүрэлдэхүүнд орсон ч гэсэн маш их эрсдэлтэй нөхцөлд харанхуйгаар л явж байсан. Надаас 10 дахин илүү эрсдэлтэй нөхцөлд тэд маань явж байсан байхгүй юу. Орчин үед юм бүхэн хөгжиж байна шүү дээ. Тухайлбал, тэр үед өмсдөг байсан хувцсыг өнөөгийн бидний хувцастай зүйрлэвэл эрс ялгаатай. -70 градуст ажрахгүй хэр нь нимгэнхэн термо хувцас өмсөөд явдаг. Ямар ч усанд унасан үхэхээргүй тийм гадуур хувцастай явдаг. Тэр үеийн хүмүүст хөлдөж үхэх эрсдэл ойрхон байсан бол өнөөдөр ийм эрсдэлээс зайлсхийх магадлал маш өндөр болчихсон. Ганцхан тэнд хүн хэр удаан тэсч чадах вэ, амьдарвал яах вэ гэдэг нь арай ондоо асуудал болчихож байгаа юм. Мэдээж, тэр хүмүүсийн ярьсан, бичсэн номууд бол байгаа. Үүнийг үзээд тэдэнтэй уулзсан хүмүүс ч бий. Тухайн үедээ энэ нь мөрөөдөл л байсан. Би Антарктид судлалыг гурван үед хувааж үздэг. Хамгийн анхных нь 1910 оны үед Руаль Амундсен, Роберт Скоттын үед монгол морь тэнд хүрсэн. Монголын нэр нь үл мэдэгдэх хоёр адуучин Хөвсгөл нутгаас Скотт ахмадын багт орж яваад Антарктидын эрэгт хүрсэн байгаа юм. Дараагийнх нь социализмын үед ЗХУ-ын экспедицийн бүрэлдэхүүнд Ж.Цэрэндэлэг гуай, Д.Чулуунбат гуай хоёр арав арван жилийн зайтай оролцоод бүтэн жил тэнд ажиллаж амьдарсан. Бүтэн жил гэдэг бол нормальный хүн тэнд байх боломжгүй хугацаа. Гуравдахь нь одоо буюу бидний үе. Би А.Батболдыгоо эхэлж явуулсан юм. Дараа нь би дөрвөн удаа Болгарын бүрэлдэхүүнд орж Ливингстоны арал дээр очоод, нэг удаа олон улсын экспедицийн бүрэлдэхүүнд орж Өмнөд туйлд хүрч нийтдээ таван экспедицид орсон. Түүний дараа манай далайчин Д.Ганбаатар гэдэг залуу явлаа. "Ус"-ны Д.Батмөнх гэдэг хүн явсан. Цаг уурч Х.Пүрэвдагва гэдэг залуу явсан. Өнгөрсөн жил Эрдэнэтийн судлаачид, инженерүүд явлаа. Мөн Японы экспедицийн бүрэлдэхүүнд манай нэг геологич шавь маань ороод явсан. Гавьяат уулчин Б.Гангаамаа Винсоны оргилд гарлаа. Түүний өмнө "Шар айраг"-ын Г.Ганхүү бас энэ оргил дээр гарч байсан. Монголчуудын хувьд Антарктид тив хол биш болжээ. Чингис хааны удмынхан дэлхийн хагасыг эзэлж байсан үе бий. Тэр үед "Уяхан замбативийн наран"-г дуулдаг байсан байгаа юм. Нарны тухай хүмүүс мэдэж байсан юм чинь дэлхийнхээ тухай мэдэж л байсан байж таараа.

**-Өмнөх хоёр үе маань олон улсын экспедицийн бүрэлдэхүүнд орж, заавар даалгавраар нь хөдөлмөрлөж байсан. Нэг талаараа бие даах эрхгүй байлаа. Харин таны үед зөвхөн монгол хүний хөлийн мөрийг үлдээх биш монгол гал голомт тэнд бий болж буй юм байна гэж ойлгож байгаа?**

-Олон улсын Антарктидын гэрээг 1959 онд үзэглээд 1962 онд анхны 12 улс гэрээнд гарын үсэг зурсан. Тэр улсууд Антарктидын хамгийн анхны гэрээний Засгийн газрын гишүүд нь. Одоогоор энэ гэрээнд 54 улс нэгдээд байна. Монгол Улс 53 дахь гишүүн нь. Монгол Улс 2015 оны зургадугаар сард Антарктидын конвенцид гишүүнээр элссэн. Өмнө нь бид дандаа зочин гишүүнээр очдог байсан бол одоо Антарктидын конвенцийн бүрэн эрхт гишүүн болсон учраас бидэнд өөрийн гэсэн хөтөлбөр, баг, бааз, мэргэжилтнүүдтэй байх ёстой. Монгол Улсын Гадаад харилцааны яам, Байгаль орчны яам, Боловсролын яам 2015 онд хамтран энэ конвенцид элсэх бүх бэлтгэлийг хийж тодорхой мэргэжлийн хүмүүс үүн дээр ажиллан УИХ-аар соёрхон батлаж АНУ-ын Төрийн департамент "ok" хэмээн зөвшөөрч байлаа. Нэгэнт УИХ соёрхон баталж, олон улсын гэрээнд нэгдсэн учраас жилийн төсөвт төлдөг тэр 20 мянга ч юм уу, 30 мянга ч юм уу ам.долларыг Сангийн яам батлаад оруулж байх ёстой юм. Тэгээд жил болгоны хөтөлбөрт оролцоход Монгол Улсын Засгийн газраас дэмжлэг үзүүлэх хэрэгтэй болов уу. Бид одоо тэнд баазаа байгуулж байгаа. Жилд 5-6 монгол хүнийг хүлээн авах хүчин чадалтай. Үүнийг би төр засгийн дэмжлэггүйгээр хийгээд дуусч байна. Гэхдээ дэмжээсэй гэж хүсдэг. Уг нь төсөл маань 250-300 ам.долларын үнэтэй. Найз нөхөд, шавь нар маань хамгийн их тусалсан. Энэ жил би өөрөө нэг яваад ирнэ. Тэгээд жилд 5-6 хүнийг хэнийг ч гуйхгүйгээр хүлээж авна даа. Энэ зардал бол улсын начин төрүүлдэг тэр л мөнгө. Өнөөдөр яагаад Хятад, Өмнөд Солонгос, Европын холбоо, Орос тэнд долларыг тэрбум, тэрбумаар нь зараад байгаа юм бэ. Тэнэг хүмүүс ийм зүйл хийхгүй шүү дээ. Тиймээс бид их том зүйлийн төлөө явж байгаа юм. Өөрөөр хэлбэл, бид тэнд үргэлж өөрийн гэсэн хэсэгтэй байж байх ёстой. Тэнд монголчуудыг НҮБ-ын индэрээс дутахааргүй сурталчлах талбар болно.

> ...Антарктидыг судална гэдэг бол дэлхийн зургаа дахь тивийг судална гэсэн үг. Тиймээс энэ нь олон улсын харилцааны асуудал юм. Антарктидын конвенцид элсэнэ гэдэг бол Монгол Улсын гадаад харилцааны бодлого. Тиймээс энэ чинь дипломат албатай холбоотой л зүйл. Хувь заяагаар би Болгарт сургууль төгсч, тэнд удаан амьдарсан хүн...

**-Нийгэмд бас өнөө маргаашаа яая гэж байж тэр мөсөн дунд юугаа хийдэг юм бэ гэж үгүйсгэх хэсэг бий. Харин та юу гэж хариулах бол?**

-Хорвоо дэлхийн амьдрал биднээр дуусахгүй. Дэлхий ертөнц биднээс хэдэн сая живаа жилийн өмнө ч, биднээс хойш хэдэн сая жилийн дараа ч байж л байх болно. Харин хүн төрөлхтөний хойч үе хязгааргүй орон зайд амьдарна. Тиймээс өнөөдөр бүгдийг заавал ч үгүй таван төгрөгөөр хэмжиж харахын оронд үүнд Монголоо яаж оролцуулах вэ гэдгийг бодолцох л ёстой. Бид 10 гаруй жил ажиллаад бүхэл бүтэн багийг бий болгочихлоо. Өнөөдөр Монголоос Антарктид тивд ихэвчлэн цаг уурын инженерүүд очиж байна. Гэтэл тэнд хүн юу идэж, юу өмсөх ёстой юм бэ. Цаашилбал, эрүүл байхын тулд яах ёстой вэ гэдгийг судлахын тулд эмч нар, тогооч нар очих ёстой. Бүр монголчууд яагаад маш эрсдэлтэй нөхцөлд адаптацид хурдан ордог вэ гэдгийг хүртэл очиж судлах хэрэгтэй байхгүй юу. Тиймээс бидний дараагийн үе бэлэн байх ёстой. Японууд Антарктидын аялал жуулчлал гэж гайхалтай сайхан зүйлийг хийж байна. Жилд 10 мянган япон хүн мөсөн тивийг зорьдог болсон. Дахиад ард нь 600 мянган хүн дугаарлаж байна. Очерт орсон сүүлчийн хүн 60 жилийн дараа тэнд очихоор байгаа юм. Тэр агуу их гайхамшигтай цэвэр лobаротари, дэлхийн дулаарлыг зохицуулж байдаг байгалийн хөргөгч, дэлхийн цэнгэг усны нөөцийг цэвэр ариун байлгахын зэрэгцээ хүмүүсийн амьдрах орчныг Антрактидад яаж бүрдүүлэх вэ гэдэгт шинжлэх ухааны салбар анхаарлаа хандуулж байна. Өнөөдөр дэлхийн хүн ам долоон тэрбумд хүрлээ. Удахгүй ес, арван тэрбум болно. Дэлхий 30 тэрбум хүнийг амьдруулах чадалтай. Харин түүнээс дээш болчихвол яах вэ. Заавал ч үгүй цөмийн дайн болох ёстой юм уу.

**-Тэгвэл Антарктидад хүн амьдрах орчин байна уу. Үүнийг мэдэхгүй мянга мянган хүн бий. Тухайлбал, тэнд өдөр шөнө ээлжилдэг үү. Зуны улирал гэж байна уу. Одоо тэнд ямар улирал болж байгаа бол. Та нар очоод хоол хүнсээ яаж боловсруулж иддэг юм бэ. Нөөшилсөн хүнсээ л гал түлээд халааж иддэг юм уу. Мод ургамал байна уу гээд олон мэдэхгүй асуулт байна?**

-Тэнд ямар ч мод, ургамал тэр байтугай ямар ч вирус байхгүй. Тиймээс хамгийн сүүлчийн асуултаа март. Идэж уухдаа ч санаа бүү зов. Шинжлэх ухаан хөгжиж байна. Хүмүүс идэх уухаа эх газраасаа аваад очдог болчихсон. Тэнд газ аваад оччихно. Хоолоо хийгээд иднэ. Тэр битгий хэл халуун усанд орж, саунд ч сууж болно. Зурагт ч үзэж болно. Гэхдээ тэр газар чинь бидний цэвэр усны нөөц байхгүй юу. Дэлхийн хуурай газрын 10 хувийг эзлэх хэмжээний хөрстэй газар дээр дунджаар 2400 метр зузаантай мөс байгаа. Харин Хойд мөсөн далай бол хөлдчихсөн далай юм. Сүүлийн 10 жилээс энэ жил анх удаагаа хайллаа. Харин одоо Антарктидад жилийн дундаж температур -74-өөс -80 градус байгаа. Гэхдээ зургадугаар сараас наймдугаар сар хүртэл Оросын экспедицийнхний хэмжсэнээр -90, -92, -94 градус хүрч байсан нь тэмдэглэгдэж үлдсэн. Тэнд нар баруунаас мандаж, зүүн зүгт шингэдэг. Ус буруу урсдаг. Цагаан баавгай тэнд үрждэггүй. Тэнд очиж байгаа хүн бүхэн өөрөө судалгааны обьект болдог.

**-Та Антарктид судлаач, газрын тосны инженерээс гадна олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Элчин сайд хүн. Олон улсын харилцаанд маш чухал үүрэгтэй, Монгол Улсыг төлөөлөх элч төлөөлөгч учраас энэ цолыг хэн бүхэнд хүртээхгүй нь ойлгомжтой. Та дипломат албанд хэдий үеэс зүтгэв. Дипломат алба таныг сонирхов уу. Эсвэл та өөрөө дипломат албыг сонирхов уу?**

-Антарктидыг судална гэдэг бол дэлхийн зургаа дахь тивийг судална гэсэн үг. Тиймээс энэ нь олон улсын харилцааны асуудал юм. Антарктидын конвенцид элсэнэ гэдэг бол Монгол Улсын гадаад харилцааны бодлого. Тиймээс энэ чинь дипломат албатай холбоотой л зүйл. Хувь заяагаар би Болгарт сургууль төгсч, тэнд удаан амьдарсан хүн. Болгарын экспедицитэй хамтраад Антарктид руу таван удаа явчихсан байх үед надад ийм боломж гарч ирсэн. Антарктид судлалыг цаашид авч явахын тулд энэ албыг санал болгоход нь би татгалзаагүй. Түүнээс биш би албан тушаал хөөцөлдөж байсангүй. Би Болгарт дээд сургууль төгсөөд тэнд дэд эрдэмтэн, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалаад таван жил Антарктидийн экспедицид ажиллаж, дөрвөн жил Элчин сайдаар томилогдож нийтдээ 20 жил амьдарсан. Манай гэр бүлийнхэн бүгдээрээ болгараар ярьдаг. Миний хоёр дахь эх орон.

**-Өнөөдөр Болгар-Монголын харилцаа ямар төвшинд байна вэ?**

-Жаахан түвэгтэй. Яагаад гэвэл, бид аль аль нь социалист улс байсан. Тэр үеийн харилцааг одоотой харьцуулах аргагүй. Хуучин социализмын үед Болгар-Монголын харилцаа сайхан байлаа. 1950 онд дипломат харилцаа тогтоосон. Энэ жил 67 жилийн ой болж байна. Болгарын техник, эдийн засгийн тусламжтайгаар Дарханы нэхий эдлэлийн үйлдвэр, Шарын голын жимс, ногооны аж ахуй, Баянхонгорын Жаргалантын алтны уурхай, Дорнодын мах комбинат, Говь-Алтай, Өвөрхангайн тоосгоны үйлдвэр, мөн IV цахилгаан станцын ойролцоо "Дэвшил" сангийн аж ахуй байгуулж байсан түүхтэй. Дээрээс нь манай улсын урлаг, спорт, техникийн шинжлэх ухааны чиглэлийн анхны томоохон мэргэжилтнүүд тэнд төгсч байлаа. Болгарт төгссөн Ардын жүжигчин зургаа, гавьяат гэхэд л 40 гаруй хүн байна. Орчин үеийн мэргэжлийн урлагийн байгууллагыг тэд босголцсон. Социализмын үед ардчилсан Германы дараах харилцаатай улс нь Болгар байлаа. Тэнд нийтдээ 700 гаруй хүн дээд сургууль төгсч, 3000 гаруй хүмүүс мэргэжил дээшлүүлсэн юм. Зарим үедээ өнөөдрийн ханшаар тооцох аргагүй, хэмжээлшгүй их мөнгөөр хоорондоо харилцаатай байсан. Монголчууд Болгар руу мах, архи, нэхий дээл явуулдаг. Болгараас мөн архи, бүх төрлийн тамхи, эм, марль, брезент авдаг байсан. Харилцаа нэг хэсэг тасарсан ч одоо эргээд сэргэж байгаа. Бид кирилл үсгийг хэрэглэдэг. Оюун санааны хувьд ч сонирхолтой, түүхэн боломж бидэнд бий. Болгарууд Хүннүгийн үед Аттила хааны дараахан энд ирж амьдарч байгаад буцаж нүүсэн. Адилхан нүүдэлчин омгийн хүмүүс. Өнөөдөр ч үүнийгээ дурсцгаадаг. Жаахан европжсон ч бидэнтэй адилхан зан араншинтай хүмүүс. Түүнээс биш өглөг авлаг, өр ширний асуудал байхгүй. Одоо зөвхөн найрамдалт харилцаа л байна.

**-Антарктидад та Монголын Консулын газрыг нээлээ гэж байсан. Энэ нь яг ямар учиртай юм бэ?**

-Тэнд хэн ч виз хэрэглэдэггүй. Гэхдээ тэнд дэлхийн цэнгэг усны нөөц бий. Тэгээд ч хэний ч биш газар үргэлж ашиг сонирхлын зөрчлийг өдөөж байдаг. Тийм учраас 2009 онд монгол гэр аваачиж барин төрийн далбаагаа мандуулан анхны баазаа байрлуулж байлаа. Энэ нь миний ирээдүй хойчийнхоо төлөө хийсэн гавьяа юм. Өөрөөр хэлбэл, "Энэ манай газар шүү", "Бид энд бүрэн эрхтэй шүү" гэж баталгаажуулсан гэх үү дээ. Одоо бол Монголын бааз өөрийн гэсэн усан онгоцны зогсоол, цаг уурын станц, өрөм тавиад хайгуул хийх чадалтай болж эхэлж байна. Ирээдүйд тэнд судлаачдаас гадна жуулчид очдог болно. Гэхдээ өнөөдрийг хүртэл дандаа л хүний юманд гуйж дайгдсаар л байгаа. Тиймээс өөрийн гэсэн юмтай, унаатай болох хэрэгтэй.

**-Зургаа дахь тивийг оцон шувуугүйгээр төсөөлөхөд бэрх. Ер нь тэндэхийн амьтад шинэ зочдоо хэр найрсаг хүлээж авдаг вэ?**

-Хүмүүст эхлээд хоёр зүйлийг сануулъя. Антарктид бол цэвэр мөсөн тив. Харин эрэг хавиар нь цэнхэр халим, далайн хав, пингвин амьдардаг. Гэхдээ Антарктидын бэлгэ тэмдэг бол оцон шувуу. Энэ чинь их гайхамшигтай. Тэр 15 сая км хавтгай дөрвөлжин нутгийн хилийг Атлантын далай, Номхон далай, Энэтхэгийн далай ирж тэнд Өмнөд далай гэдэг газар зүйн цоо шинэ ойлголтыг бий болгодог. Тэр хүйтэн усанд асар их биологийн нөөц бий. Түүгээр хооллож амьдардаг амьтад нь далайн хав, цэнхэр халим, оцон шувуу юм. Гэхдээ энэ хэдээр хооллодог галт шувуу ч бий. Оцон шувууны тухайд бол асар ухаантай амьтан. Хосоороо амьдардаг. Нэг нь үхэхэд ахиж гэрлэх тухай ойлголт байдаггүй. Их сониуч, ухаантай амьтад болохоор үргэлж хүнд ойрхон байхыг хичээдэг. Бараг л нийгмийн зохион байгуулалттай амьтад. Үржлийн үедээ хөгшчүүл нь дүрсгүйчүүдээ аваад тусдаа байрладаг. Аав, ээж нь өндөг хагарч дэгдээхэй болтол нь жижгүүдтэйгээ хамт байдаг. Ингэхгүй бол сахилгагүй нөхөд өндгийг нь гишгээд хагалчих гээд байдаг юм билээ. Сүлд дуу дуулахаар баазын ойролцоо ирж ёсолчихоод явдаг пингвин ч бий.

# ЗАВСАРЛАГА

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ



## “Дээд” ЗУРАГ

Б.СУМЪЯА

Хоёр, дөрөв, тав түүнээс ч олон давхар барилга сүндэрлэнэ. Барилгын цонх нь бүгд харанхуй. Гэхдээ дунд нь цор ганц зүйл гэрэлтэх аж. Энэ бол дэлхийн ганцаардмал, хаагдмал улс гэгддэг Хойд Солонгосын таван жилийн өмнөх дүр төрх. Тэрхүү олноо өргөгдөн гэрэлтэх зүйл бол тус улсыг үндэслэгч Ким Ир Сений хөрөг зураг ажээ. Энэ агшныг 2011 оны аравдугаар сарын 5-ны өдөр “Ройтерс” агентлагийн гэрэл зурагчин Дамир Саголж дурандаа буулгасан байна. Тэрбээр Босни ба Херцеговина улсын нийслэл Сараево хотод 1971 онд төрж, 1997 оноос Ройтерс агентлагийн гэрэл зурагчнаар ажиллаж эхэлжээ. Түүнээс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд Ойрхи Дорнод, Америк, Балканы орнууд, Хойд Солонгос зэрэг улс гүрнүүдэд ажиллаж, алдартай цуврал зургуудаа авч байв. Харин бидний өнөөдөр сонирхуулж буй эл зураг 2012 оны дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “World press photo” наадмын өдөр тутмын амьдрал төрөлд тэргүүн байр эзэлсэн юм. Ким Ир Сен агсан цэл залуу 33 насандаа Хойд Солонгосын "удирдагч" болсон бөгөөд 1994 онд 82 насандаа ертөнцийн мөнх бусыг үзүүлтлээ төрийн эрх барьсан юм. Энэ үзүүлэлтээрээ нэгэн төрлийн дээд амжилт тогтоодог. Сталинаас 40 жил Мао Зе Дунаас 20 жил илүү насалж, Өмнөд Солонгосын зургаан ерөнхийлөгч, АНУ-ын есөн ерөнхийлөгч, Японы 21 ерөнхий сайдыг элээжээ.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 28
Шөнө 12

Нөгөөдөр
Өдөр 30
Шөнө 14

### Өдрийн зурхай

**ЗУНЫ ЭХЭН ХӨХӨГЧИН МОГОЙ САР ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААН ЛУУ ӨДӨР**

**Үс засуулбал:** Хэрүүл тэмцэл ирнэ

**Наран ургах, шингэх:** 04.53-20.51



*Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, эрдэнийг гадагш өгөхөд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар явaap одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Зуны туйл болох улирал 12 цаг 45 минутад эхэлнэ. Халууны ес эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.*

## ЭМГЭНЭЛ



“Хөвсгөл Эрчим Хүч” ХХКомпанийн гүйцэтгэх захирал Монхоон Пүрэвсүрэн 2017 оны зургадугаар сарын 19-ний өдөр ажил үүргээ гүйцэтгэж яваад зуурдаар нас нөгчиж, МАН-ын журмын нөхөд бидэнд нөхөж баршгүй гарз тохиолоо.

Монхоон Пүрэвсүрэн нь 1969 онд Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд төрсөн. 1987-1992 онд Монгол Улсын ШУТИС- ийг Дулааны инженер мэргэжлээр, 1994-1997 онд Монгол Улсын ШУТИС- ийг хүнсний технологич мэргэжлээр тус тус төгсөж, 2010 онд цахилгааны мэргэшсэн инженер, 2014 онд Монгол улсын дулааны зөвлөх инженерийн зэрэг тус тус хамгаалсан юм.

М. Пүрэвсүрэн нь 1992 – 1996 онд Хөвсгөл аймгийн Цагаан – Уул сумын “Бадрал” нэгдлийн аж ахуйн нярав, тооцооны нягтлан бодогчоор ажил амьдралын гараагаа эхэлж, 2000-2001 онд “Хөвсгөл ХАА” ХХК-д ерөнхий инженер, 2001- 2006 онд “Мөнгөн Үсэг” ХХК- ийн захирал, 2003-2009 онд “Нэмэх Хасах” ХХК – ийн ерөнхий инженер, захирал, 2003-2006 онд “Номин даатгал”ХХК-ийн Хөвсгөл аймаг дахь салбарын захирал, 2009 оноос “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК –ийн захирлаар ажиллаж өөрийн авъяас билэг, хүч хөдөлмөрөө нутаг орныхоо хөгжил дэвшлийн төлөө зориулан ажиллаж ирсэн авъяаслаг удирдагч, тэргүүний сэхээтний нэг байлаа.

Тэрээр 2008-2016 онуудад Цагаан-Уул сумын иргэдийнхээ итгэлийн хүлээн аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр 3 удаа сонгогдож, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч, Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны гишүүнээр, аймгийн МАН-ын хорооны Тэргүүлэгч гишүүн, Цагаан-Уул сумын МАН-ын дарга, Цагаан-Уул сумын Нутгийн зөвлөлийн дарга, аймгийн Волейболын холбооны тэргүүлэгчээр тус тус сонгогдон үр бүтээлтэй ажиллаж байлаа.

Талийгаач М.Пүрэвсүрэн нь аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгчээр сонгогдон ажиллах хугацаандаа Нутгийн өөрөө удирдах байгууллагыг хөгжүүлэх, бэхжүүлэх, ард иргэдийнхээ элч төлөөлөл нь байж аймаг орон нутгийнхаа хөгжлийн бодлогыг тодорхойлох, иргэд, ААН, албан байгууллагуудыг найдвартай эрчим хүчээр хангахын төлөө идэвх санаачилга гарган ажиллаж байсан юм.

Түүний хичээнгүй хөдөлмөр, зүтгэлийг төр засгаас өндрөөр үнэлж Түлш эрчим хүчний салбарын Тэргүүний ажилтан, Эрчим хүчний салбарын Шилдэг удирдагч, Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны хүндэт медаль, Эвлэлийн төв хорооны Алтан медаль, Биеийн тамир спорт хорооны Тэргүүний ажилтан, Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”, “Алтан гадас” одон болон бусад ойн медалиудаар шагнаж урамшуулжээ.

Талийгаачийн улс орныхоо төлөө зүтгэсэн нөр их хөдөлмөр, шулуун шударга, ажилч хичээнгүй, нөхөрсөг зан чанар, хүнлэг, энэрэнгүй сэтгэл бидний сэтгэл зүрхэнд үүрд дурсагдан үлдэх болно.

Гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд, ах, дүү хамаатан садан, найз нөхдөд нь гүн эмгэнэл илэрхийлье. Ум сайн амгалан болтугай.

ОДДЫН АМДРАЛ

## Оскарын шагналт жүжигчин Дэниэл Дэй Льюиз тэтгэвэртээ гарлаа



Б.СУМЪЯА

Эдүгээ 60 настай Английн жүжигчин Дэниэл Дэй Льюиз кино урлагаас “зодог тайлж” буйгаа мэдэгдлээ. Тэрбээр 1989 онд дэлгэцнээ гарч байсан “My Left Foot”, 2007 оны “There Will Be Blood”, 2012 оны “Lincoln” зэрэг киногоороо нийтдээ гурван удаа Оскарын шилдэг гол дүрийн эрэгтэй жүжигчин шагналыг хүртсэн юм. Түүнээс өөр Оскараас гурван удаа шилдэг жүжигчний шагнал хүртсэн уран бүтээлч байгаагүй юм. Гэвч, 60 насны босго алхсан тэрбээр урлагаас тэтгэвэртээ гарч буйгаа төлөөлөгчөөрөө дамжуулан мэдэгдсэн байна. Түүний бие төлөөлөгч “Варьети” сэтгүүлд “Дэниэл Льюиз цаашдаа жүжигчнээр ажиллахгүй. Тэр өнөөдрийг хүртэл олон жил сарын хугацаанд хамтарч ажилласан багийнхан болон үзэгчдээсээ өршөөл хүссэн. Энэ түүний хувьд хүндхэн шийдвэр байсан” гэж ярьжээ. Ямартай ч, ирэх арванхоёрдугаар сард АНУ-д нээлтээ хийх “Phantom Thread” кино түүний жүжигчний карьерын сүүлчийн уран бүтээл байх бололтой.

### Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

Selenge Eko



Сая автобусанд ногоо аваад орлоо. Хүн бага байсан болохоор хажуудаа тавиад сандал дээр суусан юм. Тэгээд жолооч хурдтай явсан чинь уутны амсарт байсан байцаа урагшаа өнхөрөөд жолоочийн хажууд оччихсон. Гэтэл жолооч тормосоо гишгээд “Май байцаагаа аваарай” гэсэн чинь буцаад өнхрөөд над дээр ирэх жишээний. Тэгсэн манай хүү бүүр аймар уурлаад “Та одоо яагаад байгаа юм” гэнэ ээ. Би “яасан бэ” гэсэн чинь “Та хоёр одоо хаашаа юм. Харилцаж тоглоод байгаа юм уу” энэ тэр. “Юу өөрөө л өнхрөөд явчихлаа шүү дээ. Юун сүртэй юм” гэсэн чинь “Тэгээд дахиад өнхрүүлээч. Аав байхгүй байхад маяглаад” гэж үү. Өмнөөс нь хардаад байгаа юм биш үү.

ДУУЛГАХ СОНИН

## Г.АРИУНБААТАР өнөөдөр эх орондоо ирнэ

Их британи, Умард ирландын нэгдсэн вант улсын Уэлсийн нийслэл Кардиф хотноо зохион байгуулагдсан "BBC Cardiff Singer of the World-д тэргүүн байр эзэлж, дэлхийн шилдэг таван дуучны нэгээр тодорсон Чингис хаан одонт, МУГЖ Г.Ариунбаатар өнөөдөр эх орондоо ирэхээр болжээ. Түүнийг Төв аймгийн Нутгийн залуучуудын холбоо Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудалд угтаж, ёслолын үйл ажиллагаа зохион байгуулахаар болсон байна.

Тодруулбал, өглөөний 06:30 цагт Чингис хаан нисэх онгоцны буудалд угтаж авах үйл ажиллагаа болж, дараа нь Г.Ариунбаатарын ажил амьдралын гараагаа эхэлж байсан Цагдаагийн Сүлд чуулгаас дуучинд хүндэтгэл үзүүлэх юм байна. Харин 09:30 цагт дуучин хүү Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэхээр болжээ. Г.Ариунбаатар нь Төв аймгийн Баян-Өнжүүл суманд 1988 онд төрсөн билээ.

## “Үлэмжийн чанар”-ыг БҮХ НИЙТЭЭР ДУУЛНА ГЭВ

“Туурайн төвөргөөн” 2017 олон улсын хөгжмийн их наадмын нээлтийн үйл ажиллагаа энэ сарын 22-нд Монголын Бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдийн талбайд болно. Энэ үеэр Ноён хутагт Данзанравжаагийн “Үлэмжийн чанар” дууг бүх нийтээр дуулах гэнэ. Мөн хийдийн тэргүүн их хамба лам СГЗ гавж Д.Чойжамц, Да лам Х.Бямбажав, Хансүх, Гавж Д.Нанзаддорж тэргүүтэн лам хуврагууд айлдвар сургаалиа айлдах юм байна.

Дэлхийн шилдэг 50 соёлын арга хэмжээгээр албан ёсоор шалгарсан “Туурайн төвөргөөн 2017” олон улсын хөгжмийн их наадмыг зургаадугаар сарын 22-ны өдрөөс долоодугаар сарын 4-ний өдрүүдэд Улаанбаатар-Өвөрхангай Хархорин Эрдэнэзуу хийд-Сайншанд Хамрын хийд хэмээх түүхэн газруудад зохион байгуулахаар болжээ.

Тус наадамд уртын дуучид ая дуугаа өргөхөөс гадна “Шилмэл загвар” салоны хамт олон Бурхадын өмсгөл загваруудаа танилцуулж, Профессор Бернхард Вульф төгөлдөр хуурын ая эгшгээр тахил өргөх юм байна.